

Цөмийн энергийн комиссын

2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн

01 дугаар тогтоолын хавсралт

ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Зорилго

Хүн болон байгаль орчныгионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалын аюулгүй ажиллагааны шаардлагуудыг тогтооход энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Хамрах хүрээ

Энэхүү дүрэм нь гамма, рентген, бета, альфа, нейтрон, хүнд ион гэх мэт ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахад хэрэглэгдэнэ.

Ионжуулагч цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн энэхүү дүрмийг мөрдөнө.

Энэхүү дүрмийг цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг импортлох, ашиглах, хадгалах, тээвэрлэх, экспортлох, цацраг идэвхт хаягдлын менежмент хийх, цөмийн төхөөрөмж барих, ашиглах гэх мэт цацрагтай холбоотой бүхий л үйл ажиллагаанд мөрдөнө.

Хоёр. Цацрагийн хамгаалалт, аюулгүй

ажиллагааны ерөнхий шаардлагууд

2.1. Цацрагийн хамгаалалтын үндсэн зарчмууд

2.1.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий бүх аж ахуйн нэгж, байгууллагууд цацрагийн хамгаалалтын үндсэн зарчмуудыг бүх шарлагын нөхцөлүүд буюу

төлөвлөгдсөн шарлага, ослын шарлага, үүсэж тогтсон шарлагын нөхцөлүүдэд хангаж ажиллана.

2.1.2. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагууд нь үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангана. Ямар нэгэн цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаа болон цацрагийн шарлагын хэрэглээний ач тус нь түүний эрсдэлээс их гэдэг нь тогтоогдоогүй бол тухай цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаа явуулахыг хориглоно. */Аюулгүй ажиллагаа гэж ионжуулагч цацрагтай аюулгүй ажиллах, цацрагийн сөрөг нөлөөллөөс цацрагтай ажиллагч болон хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ/*

2.1.3. Ослын шарлагын нөхцөл болон үүсэж тогтсон шарлагын нөхцөлийн үед аврах, хамгаалах болон нөхөн сэргээх арга хэмжээг үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангасан үед хэрэгжүүлэх ба хамгаалалтын стратегийн дагуу гүйцэтгэнэ.

2.1.4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий бүх аж ахуйн нэгж, байгууллагууд төлөвлөгдсөн шарлага, ослын шарлага, үүсэж тогтсон шарлагын нөхцөлүүдэд цацрагийн шарлагын тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.5. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд эмнэлгийн шарлагаас бусад шарлага буюу мэргэжлийн шарлага, хүн амын шарлагын үед зөвшөөрөгдөх тунгийн хязгаараас илүүгээр өртүүлэхийг хориглоно.

2.1.6. Цацрагийн шарлагын нөхцөл, цацрагийн эрсдэл зэргээс хамааруулан цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг зэрэглэлтэйгээр мөрдөнө.

2.2. *Хяналтын байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарна.*

/Хяналтын байгууллага гэдэг нь Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, тусгай зөвшөөрөл олгох, зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагууд юм/

Үүнд:

2.2.1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, зөвлөмжийг боловсруулан батлуулах;

2.2.2. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах зорилгоор дараах хяналтын системийг бий болгох

1. Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг бүртгэлд оруулах, хуульд заасан тусгай зөвшөөрөл (цаашид зөвшөөрөл гэнэ) олгох;
2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжид цацрагийн аюулгүйн үнэлгээ хийх;

3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжид хяналт хийх;
4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжид хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч, хариуцлага тооцох;
5. Ослын шарлагын нөхцөл болон үүсэж тогтсон шарлагын нөхцөлийн үед хийх хяналтын үйл ажиллагаа;
6. Хүн ам болон бусад сонирхогч талуудтай зөвлөлдөх, мэдээлэл өгөх үйл ажиллагаа.

2.2.3. Цацрагийн шарлагын нөхцөл, цацрагийн эрсдэлээс хамааруулан цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлагуудыг хангуулах зорилгоор дээрх хяналтын системүүдийг хэрэгжүүлэх үе шаттай арга хэмжээг батлан хэрэгжүүлэх;

2.2.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаанд оролцож буй бүх хүмүүсийг хамгаалах, аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай мэргэшил, боловсрол, сургалтын шаардлагыг хангах;

2.2.5. Үндэсний болон олон улсын түвшинд шаардлагатай мэдээлэл өгөх арга замыг бий болгох;

2.2.6. Холбогдох бусад байгууллагуудтай хамтран шинээр зохион бүтээгдсэн цацрагийн үүсгүүр, цацраг үүсгэгч аппарат төхөөрөмж, байгууламжийг ашиглалтад оруулах үед түүнд тавигдах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг тусгайлсан дүрэм, журам, стандартаар тогтоох;

2.2.7. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжтай холбоотой дүн мэдээг баримтжуулан хадгалах арга хэмжээг авах. Энэхүү дүн мэдээнд дараах мэдээллийг хамруулах. Үүнд:

1. Битүү үүсгүүр, цацраг идэвхт материал болон цацраг үүсгэгч аппарат тоног төхөөрөмжийн бүртгэл;
2. Мэргэжлийн шарлагын тунгийн дүн;
3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжийн аюулгүй ажиллагааны мэдээлэл;
4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа болон байгууламжийг ашиглалтаас гаргасан болон хаасан тухай мэдээлэл;
5. Осол, зөрчил, цацраг идэвхт материал байгаль орчинд алдагдсан тухай бүртгэл мэдээлэл;
6. Цацраг идэвхт материал болон ашигласан цөмийн түлшний бүртгэл.

2.2.8. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөх, хамтран ажиллах механизмыг бий болгох;

2.2.9. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвлөлдөн ослын болон эмчилгээний улмаас битүү болон задгай цацрагийн үүсгүүр агуулсан хүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны журам гаргах;

2.2.10. Зорилгодоо хүрэх, үүргээ гүйцэтгэх менежментийн системтэй байх, түүнд үнэлгээ хийж, тогтмол сайжруулан хэрэгжүүлэх.

2.3. *Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүрэг хариуцлага*

2.3.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүргийг хүлээнэ. Бусад оролцогч талууд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах тусгайлсан үүргийг хүлээнэ.

2.3.2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүргээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

2.3.3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүргийг дараах этгээдүүд хүлээнэ. Үүнд:

1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл эзэмшигч;
2. Зөвшөөрөл шаардагдаагүй цацрагийн үүсгүүр эзэмшигч;
3. Мэргэжлийн шарлага үүсгэх ажил олгогч нар;
4. Эмнэлгийн шарлага үүсгэгч байгууллага, эмч;
5. Ослын шарлага болон үүсэж тогтсон шарлагын нөхцөл үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллага, этгээд.

2.3.4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах тусгай үүргийг дараах этгээдүүд хүлээнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр болон цацраг үүсгэгч аппарат төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлэгч;
2. Цацраг гаргагч ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч;
3. Цацрагийн хамгаалалт болон аюулгүй ажиллагааны ажилтан;
4. Эмнэлгийн эмч;
5. Эмнэлгийн физикч;
6. Эмнэлгийн цацрагийн техникч;
7. Тусгай үүрэг хүлээсэн мэргэшсэн шинжээч, мэргэжилтэн болон бусад этгээд;
8. Үүрэг хүлээсэн холбогдох ажилтнууд.

2.3.5. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүрэгтэн нь цацрагийн шарлагын нөхцөлд тохирсон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй байна.

2.3.6. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах хүч хэрэгсэл, нөөц, арга хэмжээг тодорхойлсон байна.

2. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах явцад алдаа дутагдлыг илрүүлэх ба түүнийг залруулж, дахин давтахгүй байх арга хэмжээг авна.
4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад сонирхогч талуудтай хамтран ажиллах зохицуулалтыг хийнэ.
5. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд холбогдох бүртгэл мэдээллийг хөтөлнө.
6. Хөтөлбөрийг тогтмол хянан үзэж, сайжруулна.

2.3.7. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах анхдагч болон бусад үүрэгтэн нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд холбогдох бүх ажилтнуудыг үүргээ шаардлагын хэмжээнд биелүүлэх сургалтад хамруулж, мэргэшүүлнэ.

2.4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах менежмент

2.4.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг байгууллагынхаа удирдлага, менежментийн системийн бүрэлдэхүүн хэсэг болгон оруулна.

2.4.2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах асуудлыг байгууллагын хэмжээнд өндөр төвшинд авч үзнэ.

2.4.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь менежментийн системд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дараах элементүүдийг хамруулна. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг байгууллагын үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн шаардлагууд болон аюулгүй байдлыг хангах шаардлагуудтай уялдуулан биелүүлнэ.
2. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлэх баталгаагаар хангах төлөвлөгдсөн болон системтэй арга хэмжээг тусгана.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа нь бусад ямар нэгэн шаардлагаас шалтгаалан зөрчигдөхгүй байх ёстой.
4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны гүйцэтгэлд тогтмол үнэлгээ хийж, туршлагаас суралцан сайжруулна.
5. Аюулгүй ажиллагааны соёлыг дэмжин хэрэгжүүлнэ.

2.4.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагтай холбоотой үйл ажиллагааны эрсдэлээс хамааруулан цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны элементүүдийг менежментийн системд цогц байдлаар тусган хэрэгжүүлнэ.

2.4.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь менежментийн систем дэх цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.5 Аюулгүй ажиллагааны соёл.

2.5.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, аюулгүй ажиллагааны соёлыг дэмжин хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа хангахад бүх хувь хүн болон баг хамт олныг байгууллагын хэмжээнд бүх төвшинд дэмжинэ.
2. Байгууллагын хэмжээнд аюулгүй ажиллагааны соёлын түлхүүр ухагдахууныг ойлгож, ухамсарласан байна.
3. Байгууллага нь хувь хүн, баг хамт олныг үүргээ аюулгүй бүрэн биелүүлэхийг дэмжих ба хувь хүн, технологи, байгууллага хоорондын харилцан ажиллагааг хангана.
4. Ажилтнууд, тэдгээрийн төлөөлөл болон холбогдох бусад этгээд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны бодлого, хөтөлбөр, дүрэм, журам, төлөвлөгөө боловсруулах ажилд оролцохыг дэмжин урамшуулна.
5. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад бүх төвшинд байгууллага болон хувь хүн хариуцлагатай хандана.
6. Байгууллагын дотоодод болон холбогдох бусад байгууллагатай цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны талаар нээлттэй харилцана.
7. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны талаар асуулт тавих, суралцах хандлагыг дэмжин урамшуулна.
8. Хайхрамжгүй, бүдүүлэг байдлыг таслан зогсоохыг дэмжин урамшуулна.
9. Байгууллага нь аюулгүй ажиллагааны соёлыг байнга бэхжүүлэн хөгжүүлнэ.

Гурав. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд

цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг

хангах шаардлагууд

3.1. Хамрах хүрээ

3.1.1. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлагууд нь цацрагтай холбоотой дараах үйл ажиллагаанд хамаарна. Үүнд:

1. Цацраг идэвхт материал, цацрагийн битүү болон задгай үүсгүүр, цацраг гаргагч ахуйн хэрэглээний бараа, тэдгээрийг агуулсан багаж төхөөрөмжийг үйлдвэрлэх, нийлүүлэх, тээвэрлэх;
2. Цацраг туяа үүсгэгч аппарат тоног төхөөрөмж, шугаман хурдасгуур, циклотрон, суурин болон зөөврийн радиографийн багаж төхөөрөмжийг үйлдвэрлэх, нийлүүлэх;
3. Цөмийн эрчим хүч үйлдвэрлэх, цөмийн түлшний циклийн үйл ажиллагаа;
4. Цацрагийн үүсгүүр болон цацраг идэвхт материал, цацраг үүсгэхэд ашиглагдах бусад багаж, төхөөрөмж, программ хангамжийг эмнэлэг, аж үйлдвэр, мал эмнэлэг,

хөдөө аж ахуй, геологи, уул уурхай, аюулгүй байдлыг хангах үзлэг шалгалт, судалгаа шинжилгээнд ашиглах, импортлох, экспортлох;

5. Цацраг идэвхт ашигт малтмалыг хайх, лабораторийн болон олборлолтын туршилт явуулах, олборлох, боловсруулах, тэдгээрт холбогдох хаягдлын менежмент хийх;
6. Цацраг идэвхт хаягдлын менежмент хийх; */Цацраг идэвхт хаягдлын менежмент гэж хууль, дүрэм, стандартад заасны дагуу хаягдалд тооцогдсон материалыг цуглуулах, ангилан ялгах, боловсруулах, хадгалах, буурилах үйл ажиллагааг хэлнэ/*
7. Цацраг идэвхт материал эсвэл цацраг үүсгэгч төхөөрөмж агуулсан байгууламж, цөмийн төхөөрөмж, эмнэлгийн цацрагийн байгууламж, мал эмнэлгийн цацрагийн байгууламж, цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламж, цацраг идэвхт материалын боловсруулах байгууламж, цацрагийн шарах төхөөрөмжийн байгууламж, цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах байгууламж, тэдгээрийн ажиллагаа;
8. Хяналтын байгууллагаас тогтоосон бусад үйл ажиллагаа.

3.1.2. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлагууд нь мэргэжлийн шарлага, хүн амын шарлага, эмнэлгийн шарлагад хамаарна.

3.1.3. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлагууд нь байгалийн цацраг идэвхт материалтай холбоотой дараах үйл ажиллагаанд мөн хамаарна. Үүнд:

1. Уран эсвэл Тори-ийн задралын бүлийн ямар нэгэн цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга 1Бк/г-аас их эсвэл ^{40}K изотопын идэвхийн агуулга 10 Бк/г-аас их материалтай холбоотой аливаа үйл ажиллагаа;
2. 1-д заасан идэвхийн агуулга бүхий материалыг байгальд нийлүүлэх болон тэдгээр материалтай холбоотой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын менежмент нь хүн амын шарлага үүсгэх тул хяналт тавина;
3. ^{222}Rn ба ^{222}Rn -ын задралын бүтээгдэхүүн, ^{220}Rn ба ^{220}Rn -ын задралын бүтээгдэхүүний цацрагийн шарлага, уран эсвэл Тори-ийн бүлийн бусад цацраг идэвхт цөмүүдээс үүсэх цацрагийн шарлага нь төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагад хамаарагдах тул хяналт тавина.

3.1.4. Энэхүү дүрмийн шаардлагад нийцүүлэлгүйгээр цацрагтай холбоотой аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.2. Төлөвлөгдсөн шарлагад тавигдах ерөнхий шаардлага

3.2.1. Цацрагийн аюулгүйн нормын 10 дугаар зүйлд заасны дагуу хяналтад хамруулах төвшнөөс бага идэвхтэй цацрагийн үүсгүүрийг хяналтын байгууллагын бүртгэлд хамруулалгүйгээр ашиглахыг хориглоно.

3.2.2. Цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийн шарлагын нөхцөл, цар хүрээ, магадлал, шинж чанарт цацрагийн аюулгүйн үнэлгээ хийж, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2.3. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээний дүнг Хяналтын байгууллагад мэдүүлнэ.

3.2.4. Нэг жилээс урт хагас задралын үетэй цацраг идэвхт цөм бүхий цацрагийн үүсгүүрийг импортлох тохиолдолд түүнийг ашиглахаа больсны дараа үйлдвэрлэгчид буцаах гэрээ хийнэ. Эсвэл ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрийг хадгалах болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжид хүлээн авахыг зөвшөөрсөн тухай гэрээ хийнэ. Гэрээ хийсэн тухай хяналтын байгууллагад мэдээлнэ.

3.2.5. Ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрт цацраг идэвхт хаягдлын менежмент хийх, цацраг идэвхт материал, цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг түр болон бүр хадгалах төлбөрийн хэмжээг цацрагийн үүсгүүрийг хадгалах болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

3.2.6. Цацрагийн аюулгүйн нормын 11 дүгээр зүйлд заасны дагуу хяналтаас чөлөөлөх төвшнөөс бага идэвхтэй цацраг идэвхт материалыг хяналтын байгууллагын хяналтаас чөлөөлнө.

3.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн үүрэг

3.3.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй.

3.3.2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагааны цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, дотоодын хяналт тавих алба эсвэл ажилтныг томилно. Гэвч цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

3.3.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр болон цацрагтай холбоотой үйл ажиллагаандаа ямар нэг өөрчлөлт хийхээр төлөвлөсөн бол Хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэх ба хяналтын байгууллагын зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн өөрчлөлт хийхийг хориглоно.

3.3.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагуудыг хангаж ажиллана. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа хангах үүрэг хариуцлагаа тодорхой болгож, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, дотоодын хяналт тавих алба эсвэл ажилтныг тушаалаар томилно.
3. Цацрагийн үүсгүүр болон цацрагтай холбоотой үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны үнэлгээг тогтмол хийж гүйцэтгэнэ.
4. Хяналтын байгууллагаас шаардсан тохиолдолд цацрагийн үүсгүүр болон цацрагтай холбоотой үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ.
5. Болзошгүй цацрагийн шарлагын цар хүрээ, магадлал, түүнд өртөж болзошгүй хүний тоо, хор уршгийн магадлалд үнэлгээ хийнэ.
6. Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.
7. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэмтэй байх ба тогтмол дахин хянан үзэж, менежментийн системийн дагуу сайжруулна.
8. Цацрагийн осол бусад ослоос суралцах ба тайлан мэдээ гаргах, хүргүүлэх журамтай байна.
9. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний үр дүнтэй байдлыг тогтмол хянан үзнэ.
10. Цацрагийн үүсгүүрийн ашиглалтын хугацаанд түүний цаашид ашиглагдах боломж, эдэлгээ, хамгаалалт зэргийг шаардлагатай үед шалгаж, засвар үйлчилгээг гүйцэтгэнэ.
11. Цацраг идэвхт хаягдлын менежментийг аюулгүй гүйцэтгэнэ.

3.4. Үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчим

3.4.1. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулахад үндэслэлтэй байх зарчмыг хангана, үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхийг хориглоно.

3.4.2. Хяналтын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулахад үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангасан үед л тэрхүү үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрнө.

3.5. Цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах зарчим

3.5.1. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах зарчмыг хангана.

3.5.2. Хяналтын байгууллага нь цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах шаардлагыг тавина.

3.5.3. Хяналтын байгууллага нь цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах боломжит бүх арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар тайлан мэдээг цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдээс гаргуулна.

3.5.4. Хяналтын байгууллага нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах тунгийн хязгаарлалтын утгыг тогтооно.

3.5.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн тунгийн чадлыг Цацрагийн аюулгүйн нормын 6 дугаар зүйлд заасан цацрагийн тунгийн хязгаарлалтаас хэтрүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.6. Тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх зарчим

3.6.1. Хүн ам, цацрагтай ажиллагчдыг шарлагын тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх зарчмыг хангана.

3.6.2. Хүн ам, цацрагтай ажиллагчдыг Цацрагийн аюулгүйн нормын 5 дугаар зүйлд заасан цацрагийн тунгийн үндсэн хязгаараас илүүгээр цацрагийн шарлагад өртүүлэхийг хориглоно.

3.6.3. Эмнэлгийн шарлагын хувьд тунгийн хязгаар тавигдахгүй боловч, эмнэлгийн шарлагыг зохистой хэмжээнд байлгахад Цацрагийн аюулгүйн нормын 13 дугаар зүйлд заасан эмнэлгийн шарлагын зөвлөх төвшинг мөрдөнө.

3.7. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээ

3.7.1. Цацрагийн шарлага үүсгэх, цацрагийн эрсдэлийг үүсгэх аливаа үйл ажиллагаа болон байгууламжид цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээ хийж, зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалд оруулан Хяналтын байгууллагад мэдүүлнэ.

3.7.2. Хяналтын байгууллага нь цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээнд тавигдах шаардлагыг тогтооно.

3.7.3. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээ нь цацрагтай холбоотой үйл ажиллагааны төрлөөс хамааран газар сонгох, загвар гаргах, үйлдвэрлэх, барих, цэнэглэх, ашиглалтад оруулах, ажиллуулах, засварлах, хаах, ашиглалтаас гаргах үйл ажиллагааг хамруулсан шатлалтай байна.

3.7.4. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээнд дараах арга хэмжээг хамруулна. Үүнд:

1. Цацрагийн шарлага үүсгэх, цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх гадаад болон цацрагийн үүсгүүр түүнтэй холбоотой бусад тоног төхөөрөмжтэй холбоотой дотоод хүчин зүйл, арга замуудыг тогтооно.
2. Хэвийн үйл ажиллагааны үед цацрагийн шарлагын цар хүрээ, магадлалыг тодорхойлох ба хэвийн бус үйл ажиллагаанаас үүдэлтэй шарлагын үнэлгээ хийнэ.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ.
4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа ба байгууламжийн үйл ажиллагааны хязгаарлах нөхцөлийг хянан үзнэ.
5. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны бүтэц, систем, бүрэлдэхүүн хэсэг, программ хангамж, үйл ажиллагаанд дан буюу давхар гэмтэл гарснаас цацрагийн шарлага өгөх, осол үүсэх арга замыг хянан үзнэ.
6. Ямар нэгэн өөрчлөлтийн улмаас цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хянан үзнэ.
7. Цацрагийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд өөрчлөлт орсноос цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хянан үзнэ.
8. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөх ямар нэгэн тодорхойгүй байдал, эргэлзээ, таамаглалыг хянан үзнэ.
9. Цацраг идэвхт материал алдагдахад хүргэж болзошгүй хүчин зүйл, болзошгүй осол зөрчлийн улмаас байгаль орчинд алдагдах хамгийн их идэвхийг тогтоож, энэхүү алдагдлыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
10. Цацраг идэвхт материал бага хэмжээтэй боловч удаан хугацаанд алдагдахад хүргэж болзошгүй хүчин зүйлийг тодорхойлж, энэхүү алдагдлыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
11. Цацрагийн үүсгүүрийн хамгаалалт алдагдах, цацрагийн үүсгүүрийн үйл ажиллагаа алдагдахад хүргэж болзошгүй хүчин зүйлийг тодорхойлох, тэдгээр тохиолдлуудыг илрүүлэх, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.7.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээг баримтжуулан менежментийн системд тусгагдсаны дагуу хөндлөнгийн хараат бус үнэлгээ хийлгэж болно.

3.7.6. Шаардлагатай бол цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь техникийн үзүүлэлт, ашиглалтын нөхцөлөөс хамааруулан цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээний хүрээнд нэмэлт тодотгол хийнэ.

3.7.7. Цацрагийн аюулгүй ажиллагааны дүн эсвэл цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг сайжруулах бусад үндэслэлээр цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг сайжруулах арга хэмжээ авна.

3.7.8. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа, байгууламжид ямар нэгэн томоохон өөрчлөлт хийх бол зөвхөн цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээг хийсний дараа үнэлгээний дүнг харгалзан Хяналтын байгууллагын зөвшөөрсний дагуу гүйцэтгэнэ.

3.7.9. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн гүйцэтгэсэн цацрагтай

холбоотой үйл ажиллагаа, байгууламжийн цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээний дүнг Хяналтын байгууллага хянан шалгана.

3.8. Шаардлагад нийцэж буйг баталгаажуулах дотоод хяналт, мониторинг

3.8.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж буйг баталгаажуулах дотоод хяналт, мониторинг хийнэ.

3.8.2. Хяналтын байгууллага нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж буйг баталгаажуулах дотоод хяналт, мониторингийн шаардлагуудыг тогтооно.

3.8.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, дотоодын хяналт тавих алба эсвэл ажилтныг томилно. Энэхүү алба болон ажилтан нь “Цацрагтай холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүйн албаны тухай дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

3.8.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Дүрмийн шаардлагуудад нийцэж буйг баталгаажуулахаар дотоод хяналт, мониторинг ба хэмжилт шинжилгээг гүйцэтгэнэ .
2. Хэмжилт хийхэд тохирох багажтай байна.
3. Хэмжилтийн багажийг тохируулга, баталгаажуулалтад хамруулсан байна.
4. Хэмжилтийн багаж нь хэмжих цацрагийн төрөл, энерги, хэмжих хязгаар, цаг уурын нөхцөлд тохирсон байх баталгаажуулалт хийгдсэн байна.
5. Дотоод хяналт, мониторинг ба хэмжилт шинжилгээний дүнг баримтжуулж, хяналтын байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор тайлан гаргаж хүргүүлнэ.

3.9. Цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг багасгах.

3.9.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг бага байлгах хамгийн сайн туршлага, инженерийн шийдэл, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.9.2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь холбогдох байгууллагуудтай хамтран газар сонгох, загвар гаргах, үйлдвэрлэх, барих, цэнэглэх, ашиглалтад оруулах, ажиллуулах, засварлах, хаах, ашиглалтаас гаргах үйл ажиллагаанд хамгийн сайн туршлага, инженерийн шийдлийг ашиглах ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн байна.
2. Байгууламжийн ашиглалтын хугацаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн удирдлагын болон зохион байгуулалтын арга хэрэгслээр хангасан байна.
3. Туршлагаас суралцан техникийн хүчин зүйлийг сайжруулах арга хэмжээ авна.
4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны судалгааны үр дүнд үндэслэн техникийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээ авна.

3.9.3. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагааны цацрагийн болзошгүй шарлагын цар хүрээ, магадлалд нийцсэн дэс дараалсан, аль нэгнээсээ үл хамаарсан олон түвшний хамгаалалт, аюулгүй ажиллагааны системтэй байна. Цацрагийн хамгаалалтын нэг систем нь гэмтэхэд бусад системүүд нь ажиллаж байх зохион байгуулалттай байна.

3.9.4. Олон түвшний хамгаалалт, аюулгүй ажиллагааны систем нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

1. Ослоос урьдчилан сэргийлнэ.
2. Ослын хор уршгийг багасгана.
3. Ослын дараа хэвийн үйл ажиллагаанд шилжүүлнэ.

3.9.5. Загвар гаргах, үйлдвэрлэх, барих, ашиглалтад оруулах, ажиллуулах, засварлах, ашиглалтаас гаргах үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах систем, бүтэц, бүрэлдэхүүн, программ хангамж нь ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байна.

3.9.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр, байгууламж, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд дараах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Цацрагийн үүсгүүр, байгууламж, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд болзошгүй ослоос урьдчилан сэргийлнэ.
2. Цацрагийн ослын хор уршгийг багасгана.
3. Болзошгүй шарлагыг хязгаарлах талаар ажилтнуудыг мэдээлэл, сургалт, заавар, хамгаалах хэрэгсэл, багаж төхөөрөмжөөр хангана.
4. Цацрагийн үүсгүүр болон байгууламжид хяналт тавих үйл ажиллагаа, болзошгүй ослыг урьдчилан тооцоолох менежменттэй байна.
5. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах систем, бүтэц, бүрэлдэхүүн, программ хангамжийг тогтмол шалгаж, хэвийн бус нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлнэ.
6. Хяналт, шалгалт болон засвар үйлчилгээг гүйцэтгэхдээ мэргэжлийн шарлагын хязгаараас хэтрүүлэлгүйгээр цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд тохиромжтойгоор гүйцэтгэнэ.
7. Хэвийн ажиллагааны нөхцөл алдагдсан тохиолдол болон ослын үед байгууламжаас гарах цацрагийн алдагдлыг багасгах, аюулгүй зогсоох автомат системтэй байна.

8. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц хэвийн бус үйл ажиллагаа үүссэн үед нэн яаралтай хэвийн ажиллагаанд оруулах, хариу арга хэмжээ авах системтэй байна.
9. Цацрагийн аюулгүй ажиллагааны бүх баримт бичгүүд нь ажилтнуудад ойлгомжтой байна.

3.9.7. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээгээр хүн ам эсвэл ажиллагчдад нөлөөлөл үзүүлэх магадлалтай байвал цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хүн ба байгаль орчныг хамгаалах ослын бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулна.

3.9.8. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ослын бэлэн байдлын төлөвлөгөөнд ослын байдлыг шуурхай таних, түүнд тохирох түвшний хариу арга хэмжээ авах зохион байгуулалтын заалтуудыг тусгасан байна.

3.9.9. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ослын бэлэн байдлын төлөвлөгөөнд хариу арга хэмжээний талаар дараах зохион байгуулалтын заалтуудыг тусгана. Үүнд:

1. Хувь хүний хэмжилт, талбайн хэмжилт, эмнэлгийн тусламж;
2. Ослын үр дагаврыг үнэлэх, хор уршгийг бууруулах.

3.9.10. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд үр дүнтэй хариу арга хэмжээ авахад шаардагдах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлтгэгдсэн байна.

3.9.11. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүр, цөмийн материалд тавих хяналт алдагдах нөхцөл үүсэх, тэрхүү нөхцөл өргөжихөөс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр, цөмийн материалд тавих хяналтад алдагдахаас сэргийлэх болон тэдгээрийг хяналтандаа авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. Шаардлагатай багаж төхөөрөмж, хайлтын багаж хэрэгслийг бэлэн байлгана.
3. Ажилтнуудыг энэхүү үйл ажиллагаанд сургах ба давтан сургалт, дасгал сургуулилтад хамруулна.

3.10. Цацрагтай холбоотой үйл ажиллагааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх

3.10.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хэрэгжүүлж буй цацрагтай холбоотой үйл ажиллагаанд нь хэвийн бус нөхцөл байдал үүсвэл түүнд дүн шинжилгээ хийх

ба энэхүү хэвийн бус нөхцөл нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц байвал энэ талаар хяналтын байгууллагад мэдээлнэ.

3.10.2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц хэвийн болон хэвийн бус нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлэн байлгах ба хяналтын байгууллага болон бусад холбогдох байгууллагад мэдээлнэ. Тухайлбал энэхүү мэдээлэл нь ослын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хариу авсан арга хэмжээний мэдээлэл, цацрагийн тунгийн мэдээлэл, зөрчил, түүнийг арилгасан тухай мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны туршлагын тухай мэдээлэл гэх мэт байна.

3.10.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах дүн шинжилгээг хийнэ. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд хамаарах үзүүлэлтүүдийн тоо хэмжээ, хэвийн хэмжээнээс хэтэрсэн эсэх;
2. Багаж төхөөрөмжийн эвдрэл, осол, зөрчил, алдаа дутагдал;
3. Зөвшөөрөгдөх хэмжээ, хяналтын төвшнөөс хэтэрсэн аюултай нөхцөл байдал үүссэн эсэх.

3.10.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд осол зөрчил гарсан даруйд дүн шинжилгээг гүйцэтгэнэ.

3.10.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь энэхүү осол зөрчлийн шалтгаан эсвэл таамаглагдаж буй шалтгаан, тунгийн хэмжээ, түүний баталгаажуулалт, дахин ийм осол зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал зэргийг агуулсан тайлан бичиж Хяналтын байгууллага болон холбогдох байгууллагуудад өгнө.

3.10.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн тунгийн хязгаар зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн осол гарсан бол Хяналтын байгууллагад нэн яаралтай мэдэгдэнэ.

3.11. Цацрагийн үүсгүүр

3.11.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангана.

3.11.2. Цацрагийн үүсгүүр үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгч нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийн загвар нь зөв зохион бүтээгдсэн байна.
2. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмж нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны стандартын шаардлагыг хангасан байна.
3. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийн ажиллагаа, түүний үзүүлэлт нь стандартын шаардлага хангасан байна.
4. Хамгаалалт, аюулгүй ажиллагааны систем, программ хангамж нь чанарын стандартын шаардлага хангасан байна.
5. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийн удирдлагын самбар, дэлгэц нь ойлгомжтой, хэрэглэгчдэд ойлгомжтой, тохирох хэл дээр зохион бүтээгдсэн байна.
6. Цацраг идэвхт үүсгүүр болон цацраг үүсгэгч аппарат нь туршигдаж, стандартын шаардлага хангасан байна.
7. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах, засварлах заавар, цацрагийн аюул, үзүүлэлтүүд, хамгаалалт, аюулгүй ажиллагааны зааварчилга нь хэрэглэгчдэд ойлгомжтой, тохирох хэл дээр бичигдсэн байна.
8. Цацрагаас хамгаалах материал болон бусад хамгаалах багаж хэрэгслээр хамгаалалтыг хийсэн байна.

3.11.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч нь үүсгүүрийн нийлүүлэгч буюу үйлдвэрлэгчтэй харилцан ажиллаж дараах мэдээллээр Хяналтын байгууллага ба холбогдох бусад байгууллагуудыг хангана. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийн ашиглалтын нөхцөл, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны туршлага;
2. Тухайн үүсгүүр болон түүнийг агуулсан төхөөрөмжийн талаарх бусад хэрэглэгчийн өгсөн үнэлгээ буюу цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг сайжруулах шаардлагатай зүйлсийн талаарх мэдээлэл.

3.11.4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах газрыг сонгохдоо дараах өгөгдлийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд тавих хяналт, менежментийн хүчин зүйлс;
2. Хүн ам болон ажилтнуудад цацрагийн шарлага өгөх хүчин зүйлс;
3. Инженерийн загварчлалын хүчин зүйл.

3.11.5. Их хэмжээний цацраг идэвхт материал агуулах байгууламж байгуулах, түүнээс цацраг идэвхт материал алдагдах аюултай бол цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь тус байгууламж болон түүний байрлаж буй бүс нутгийн хамгаалалтын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлнэ.

3.11.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрийн бүртгэлийг хөтлөх ба үүнд хамгийн багадаа дараах мэдээллийг оруулна. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийн нэр төрөл, идэвх, чадал, хэлбэр, хувийн дугаар;
2. Цацрагийн үүсгүүр тус бүрийн байршил.

3.11.7. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрийн бүртгэл судалгааг хяналтын байгууллагад хуульд заасан хугацаа болон Хяналтын байгууллагын шаардсан үед гаргаж өгнө.

3.11.8. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрийг эзэнгүй орхих, гээх, алдах, зөвшөөрөлгүй этгээд авах, хулгайд алдах, гэмтэхээс сэргийлж байнга хяналтад байлгана. Үүнийг хангахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийг байнгын хяналтад байлгаж, түүнийг байрандаа байгаа эсэхийг тодорхой давтамжтайгаар шалгана.
2. Цацрагийн үүсгүүр алга болсон, алдагдсан бол хяналтын байгууллагад нэн яаралтай мэдээнэ.
3. Цацрагийн үүсгүүрийг шилжүүлэх бол хүлээн авагч нь хяналтын байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байна.

3.11.9. Цацрагийн үүсгүүр, түүнийг агуулсан багаж төхөөрөмжийг үйлдвэрлэгч нь олон улсын стандартын дагуу цацрагийн үүсгүүр, түүний сав баглаанд анхааруулах санамж тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна.

3.11.10. Цацрагийн үүсгүүрийг ашиглалтаас гаргасны дараа түүнийг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангасан газар хадгалах бөгөөд гэрээний дагуу үйлдвэрлэгчид буцаана. Буцаах гэрээ хийгдээгүй тохиолдолд ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүрийг хадгалах болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжид шилжүүлнэ.

3.12. Цацрагийн оношилгоо, эмчилгээнээс бусад зорилгоор хүнд үзлэг хийх

3.12.1. Цацрагийн оношилгоо, эмчилгээнээс бусад зорилгоор хүнд үзлэг хийхэд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангана.

3.12.2. Цацрагийн оношилгоо, эмчилгээнээс бусад зорилгоор цацрагийн үүсгүүрээр хүнд үзлэг хийх бол дараах шаардлагыг хангасан үед л хийнэ. Үүнд:

1. Хүнд үзлэг хийх үйл ажиллагааны ашиг тус нь аюул эрсдэлээс их байх тохиолдолд хэрэглэнэ.
2. Хүнд үзлэг хийх төхөөрөмж, үзлэг хийх үйл ажиллагаа нь үр дүнтэй, тохиромжтой байна.

3. Бусад хууль, тогтоомжид нийцсэн байна.
4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа хангагдсан байна.

3.12.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хууль бусаар хил давуулах наймаа, тэсрэх бөмбөг эсвэл биедээ нуусан бусад зүйлсийг илрүүлэх зорилгоор цацрагийн үүсгүүрээр хүний биед үзлэг хийхдээ тухайн хүний авах тунг аль болох бага байлгах зарчмыг баримтлах бөгөөд стандартад заасан болон хяналтын байгууллагаас тогтоосон тунгийн хязгаарлалтын утгаас хэтрүүлэхийг хориглоно.

3.12.4. Эмнэлгийн шарлага үүсгэх цацрагтай холбоотой үйл ажиллагаа үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн үүсгүүрээр үзлэг хийх хүнд цацрагийн үүсгүүр агуулаагүй бусад аргаар үзлэг хийлгэх боломж байгааг мэдэгдсэн байх ёстой.

3.12.5. Аюулгүйн үзлэг шалгалтын цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хүний биед нуусан зүйлсийг илрүүлэх энэхүү үйл ажиллагаанд олон улсын стандартын байгууллагын стандарт эсвэл олон улсын цахилгаан техникийн байгууллагын стандарт болон үндэсний холбогдох стандартад нийцсэн төхөөрөмжийг л ашиглана.

3.13. Мэргэжлийн шарлага

Хяналтын байгууллага

3.13.1. Хяналтын байгууллага нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах, цацрагийн тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах, мэргэжлийн шарлагын хувийн тунг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх шаардлагыг хангуулна.

3.13.2. Хяналтын байгууллага нь зөвшөөрөл олгохын өмнө аж ахуйн нэгж, байгууллагаас дараах материалуудыг гаргуулан авч үнэлгээ хийнэ. Үүнд:

1. Шарлага өгөх нөхцөл, түүний шалгуур үзүүлэлтүүд, осол болон хэвийн ажлын бүх үе шатанд шарлагад өртөж болзошгүй ажлын байр, ажилтнуудын тоо;
2. осол болон хэвийн ажлын бүх үе шатанд шарлагад өртөж болзошгүй ажилтнуудын мэргэжлийн шарлагын тунг үнэлэх хөтөлбөр, шалгуур үзүүлэлт.

Мэргэжлийн шарлагын хувийн тунг үнэлэх хяналт мониторинг

3.13.3. Хяналтын байгууллага нь төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт мониторингийн систем, тунгийн дүн мэдээллийг хадгалах, түүнд тавигдах шаардлагуудыг тогтооно.

3.13.4. Хяналтын байгууллага нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт, мониторингийн хөтөлбөрт үнэлгээ хийнэ.
2. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт, мониторинг, тохируулгын үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгоно.
3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт, мониторингийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, тунгийн үнэлгээг шалгана.
4. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт, мониторингийн дүнг хуульд заасан хугацааны туршид хадгалах шаардлагыг хангуулна.
5. Байгууллага аж ахуй нэгжийн цацрагтай холбоотой үйл ажиллагаа нь мэргэжлийн шарлагад тавигдах шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулна.

Ажилтнуудыг хамгаалах талаар цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогчийн үүрэг хариуцлага

3.13.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах, мэргэжлийн шарлагын тунг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

3.13.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогч нь ажилтнуудыг мэргэжлийн шарлагаас хамгаалах үүрэг хүлээнэ.

3.13.7. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогч дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

1. Ажилтнуудын авч буй мэргэжлийн шарлагын тунг хянах, тунгийн хэмжээ нь Цацрагийн аюулгүйн нормд заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй гэдгийг баталгаажуулна.
2. Цацрагийн тунгийн хэмжээг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах талаар гаргасан шийдвэр, арга хэмжээг баримтжуулна. Шаардлагатай үед хяналтын байгууллага болон холбогдох бусад байгууллагад гаргаж өгнө.
4. Цацрагийн аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цацрагийн аюулгүйн нормын шаардлагуудыг биелүүлэх бодлого, хөтөлбөртэй байх ба мэргэжлийн шарлагын хяналт мониторинг гүйцэтгэх техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5. Мэргэжлийн шарлагын цар хүрээ, магадлалаас хамааруулан цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны тохирох багаж, хэрэгсэл, байгууламж, үйлчилгээгээр хангасан байна.
6. Цацрагтай ажиллагчдыг мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн хяналтад жил бүр хамруулж, цацрагаас шалтгаалах өвчин үүсээгүй гэдгийг баталгаажуулна.
7. Цацрагаас хамгаалах тохирох хэрэгсэл, цацрагийн хэмжилтийн тохирох багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж тэдгээрийг тохируулга засвар үйлчилгээнд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.
8. Цацрагтай ажиллагчдыг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалт, давтан сургалтад 2 жил тутам, мөн мэргэшлийн төвшин ахиулах сургалтуудад хамруулна.
9. Хэмжилтийн дүн, мэргэжлийн шарлагын тунгийн хяналт, мониторингийн дүнг бичиж хадгална.
10. Цацрагтай ажиллагчдад зөвлөгөө, зааварчилга өгөх, Цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм, Цацрагийн аюулгүйн нормыг биелүүлэх, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах талаар харилцан санал солилцох зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
11. Аюулгүй ажиллагааны соёлыг бий болгох, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
12. Цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах зорилгоор зөвшөөрөгдөх тунгийн хязгаараас бага тунгийн хязгаарлалтын утгуудыг тогтоож үйл ажиллагаандаа мөрдөхийг эрмэлзэнэ.

3.13.8. Цацрагтай ажилладаггүй бөгөөд ажлын байр нь цацрагтай шууд хамаарахгүй ажилтнууд хяналтын болон ажиглалтын бүсэд ажил гүйцэтгэх, цацрагийн шарлагад өртөх бол тэдгээрийг хүн ам гэсэн ангилалд хамааруулж авч үзнэ. Тэднийг хүн амын цацрагийн зөвшөөрөгдөх тунгийн хязгаараас илүүгээр цацрагийн шарлагад өртүүлэхийг хориглоно.

3.13.9. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогч нь ажилтнуудад цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах нь ерөнхий мэргэжлээс шалтгаалах эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд цацрагийн шарлагаас өөрийгөө төдийгүй бусдыг хамгаалах онцгой үүрэгтэй гэдгийг мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.13.10. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа буюу цацрагийн эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу ажил олгогч нь ажилтнуудад энэхүү дүрэм болон Цацрагийн аюулгүйн нормын шаардлагуудыг биелүүлэхийг үүрэг болгоно.

Ажилтнууд

3.13.11. Ажилтнууд нь ажил үүргээ гүйцэтгэхдээ цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй.

3.13.12. Ажилтнууд нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

1. Ажилтнууд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг цацрагтай холбоотой үйл ажиллагаа буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн гаргасан бүх дүрэм журмыг мөрдөн ажиллана.
2. Цацрагаас хамгаалах хэрэгсэл, цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжийг байнга зөв хэрэглэнэ.
3. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, ажилтнуудын эрүүл мэндийн үйлчилгээ, тунгийн үнэлгээний хөтөлбөрийн талаар ажил олгогч, цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдтэй харилцан хамтран ажиллана.
4. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг үр дүнтэй ханган өөрийгөө болон бусдыг хамгаалан ажилласан, ажиллаж буй талаарх мэдээллээр ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийг хангана.
5. Өөрийгөө болон бусдыг дүрэм, норм, стандарт зөрчих нөхцөл байдал үүсгэхээс сэргийлэх, дүрэм, норм, стандартын шаардлагад нийцэхгүй үйл ажиллагаа явуулахаас татгалзана.
6. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалт, заавар, мэдээллийг хүлээн зөвшөөрөх ба өөрийн ажил үүргийг дүрэм, норм, стандартын шаардлагад нийцүүлнэ.
7. Ажилтнууд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа зөрчигдөх нөхцөл байдал үүссэн, хэвийн бус нөхцөл байдал үүссэн тохиолдлуудыг ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдэд мэдээнэ.

Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр

3.13.13. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөрт мэргэжлийн шарлагын хяналт, мониторингийн арга хэмжээг тусгах ба ажлын байрыг хяналтын бүс, ажиглалтын бүс гэж ангилан тэдгээрийн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хяналтын бүс

3.13.14. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны тусгай арга хэмжээ шаардлагатай талбайг хяналтын бүсэд хамааруулна. Үүнд:

1. Хэвийн үйл ажиллагааны үед цацрагийн бохирдол тархахаас сэргийлэх, цацрагийн шарлагыг хянах шаардлагатай бүс;
2. Хэвийн бус нөхцөл байдал, ослын нөхцөлд цацрагийн шарлагын цар хүрээ ба магадлалыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх шаардлагатай бүсийг хамруулна.

3.13.15.Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хэвийн үйл ажиллагааны үеийн шарлагын цар хүрээ, хэвийн бус нөхцөл байдал, ослын үеийн цацрагийн шарлагын цар хүрээ, магадлалыг харгалзан хяналтын бүсийн хил хязгаар, тэнд хэрэгжүүлэх цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны төрөл, хэмжээг тогтооно.

3.13.16. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь:

1. Хяналтын бүсийн хил хүрээг биетээр тэмдэглэн хязгаарлана, хэрэв тийм боломжгүй бол бусад аргаар тэмдэглэнэ.
2. Цацрагийн үүсгүүрийг нэг удаа түр ашиглах, эсвэл нэг газраас нөгөө газар луу байнга зөөвөрлөн ашиглах бол шарлагын хугацааны үед хяналтын бүсийг хязгаарлан тэмдэглэнэ.
3. Цацрагийн аюулын анхааруулах санамж, тэмдгийг байрлуулах ба хяналтын бүсэд нэвтрэн орох хэсгүүдэд зааварчилгыг байрлуулна.
4. Хяналтын бүсэд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, цацрагийн бохирдлыг хянах, бохирдлын тархалтыг хязгаарлах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.
5. Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэмд хяналтын бүсэд гүйцэтгэх үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагуудыг тусгасан байна.
6. Хяналтын бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх боломжийг хязгаарласан байна. Үүнд цацрагийн шарлагын цар хүрээ, магадлалыг харгалзан зохион байгуулалтын болон биет хамгаалалтыг ашиглана.
7. Хяналтын бүсэд нэвтрэх гарцыг дараах багаж төхөөрөмжөөр хангасан байна. Үүнд:

а)Хувийн хамгаалах хэрэгсэл;

б)Хувийн тун болон ажлын байрны хяналтын багаж төхөөрөмж;

в)Хувийн хувцсыг хадгалах тохиромжтой шүүгээ.

8. Хяналтын бүсээс гарах гарцыг дараах багаж төхөөрөмжөөр хангасан байна. Үүнд:

а) Арьс болон хувцасны бохирдлыг хянах багаж төхөөрөмж;

б) Хяналтын бүсээс гаргаж буй эд зүйлс, материалын бохирдлыг хянах багаж төхөөрөмж;

в) Шүршүүр, угаалгын хэрэгсэл, бохирдол арилгах бусад хэрэгсэл;

г) Бохирдсон хувийн хамгаалах хэрэгсэл, төхөөрөмжийг хадгалах агуулах сав.

9. Хяналтын бүс, түүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээнд ямар нэгэн шинэчлэлт өөрчлөлт шаардлагатай эсэхэд тогтмол үнэлгээ хийнэ.
10. Хяналтын бүсэд ажиллах хүмүүсийг сургалт, зааварчилга, шаардлагатай мэдээллээр хангана.

Ажиглалтын бүс

3.13.17. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хяналтын бүсэд хамаараагүй буюу цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны тусгай арга хэмжээ шаардагдахгүй боловч мэргэжлийн шарлагыг хянаж байх шаардлагатай талбайг ажиглалтын бүсэд хамааруулна.

3.13.18. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажиглалтын бүсэд цацрагийн шарлагын эсвэл бохирдлын цар хүрээ, магадлалыг харгалзан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Ажиглалтын бүсийн хил хүрээг тохирох аргаар тэмдэглэнэ.
2. Ажиглалтын бүсэд нэвтрэх, орох хэсгүүдэд анхааруулах санамж тэмдэг байрлуулна.
3. Ажиглалтын бүс, түүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээнд ямар нэгэн шинэчлэлт өөрчлөлт шаардлагатай эсэхэд тогтмол үнэлгээ хийнэ.

Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дотоод дүрэм ба хувийн хамгаалах хэрэгсэл

3.13.19. Ажил олгогч буюу Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахдаа хувийн хамгаалах хэрэгсэл болон зохион байгуулалт, хяналтын хэрэгцээ шаардлагыг бага байлгах аар инженерчлэл буюу техникийн шийдэл, ажлын нөхцөлийг бий болгоно.

3.13.20. Цацрагийн хамгаалалтын дээрх арга хэмжээнүүд нь дараах шатлалтай байна.
Үүнд:

- 1 дүгээрт: Инженерчлэл буюу техникийн шийдэл, ажлын нөхцөл;
- 2 дугаарт: Зохион байгуулалт, хяналт;
- 3 дугаарт: Хувийн хамгаалах хэрэгсэл;

3.13.21. Ажил олгогч буюу Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажилтнуудтай зөвлөлдөн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацрагтай ажиллагчид болон бусад хүмүүсийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах дотоод дүрэм боловсруулан батлуулна./Цацрагтай ажиллагчид гэж цацрагийн үүсгүүр, цөмийн материалтай ажиллаж буй ажилтнууд, цацрагтай холбоотой үйл ажиллагаанд шууд оролцон мэргэжлийн шарлагад өртөж буй ажилтнуудыг хэлнэ/
2. Тус дотоод дүрэмд байгууллагын хэмжээнд хяналтын зөвлөх төвшин, хязгаарын утгууд, тэдгээр утгууд хэтэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг оруулна.
3. Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэмтэй цацрагтай ажиллагчид болон цацрагийн шарлагад өртөж болзошгүй бусад ажилтнууд танилцсан байна.
4. Мэргэжлийн шарлага үүсгэх ажлын байр бүрийг хяналтандаа байлгаж, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийг биелүүлэх бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
5. Дотоодын хяналт тавих алба эсвэл цацрагийн дотоод хяналтын ажилтанг томилно.

3.13.22. Ажил олгогч буюу Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Цацрагтай ажиллагчдыг дараах тохирох хамгаалах хэрэгслээр хангасан байна. Үүнд:

а) Хамгаалалтын хувцас;

б) Амьсгалын систем хамгаалахад тохирох үзүүлэлт бүхий хэрэгсэл;

в) Хар тугалга бүхий хормогч, бээлий, нүдний шил, бусад эрхтэн хамгаалах хаалт;

2. Цацрагийн хамгаалах хувцас, хэрэгслийг хэрхэн зөв хэрэглэх талаар зааварчилга өгч, биед хэрхэн нийцэж байгааг шалгана.
3. Болзошгүй ослын үед хэрэглэх хувийн хамгаалах хэрэгсэл, багаж төхөөрөмжүүдийг бэлэн байлгаж, зөв хадгалах бөгөөд боломжтой бол тогтмол шалгаж баталгаажуулна.

Ажлын байрны хяналт, мониторинг

3.13.23. Ажил олгогч буюу Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-т ажлын байрны хяналт, мониторингийн арга хэмжээг оруулах ба дотоодын хяналт тавих алба

эсвэл цацрагийн дотоод хяналтын ажилтан нь энэхүү хөтөлбөрийг дахин хянаж, хэрэгжүүлнэ.

3.13.24. Ажлын байрны хяналт, мониторингийн төрөл, давтамж дараах арга хэмжээг гүйцэтгэхэд хангалтай байх ёстой. Үүнд:

1. Бүх ажлын байранд цацрагийн нөхцөлийн үнэлгээ хийх;
2. Хяналтын болон ажиглалтын бүсэд цацрагийн шарлага, цацрагийн тунгийн үнэлгээ хийх;
3. Хяналтын болон ажиглалтын бүсийг ангилах, түүнд дахин үнэлгээ хийх.

3.13.25. Ажлын байрны хяналт, мониторингийн төрөл, давтамж нь тунгийн чадал, агаар дахь цацраг идэвхт изотопын хувийн идэвх, гадаргуугийн бохирдол, хэвийн бус үйл ажиллагаа болон болзошгүй ослын үеийн шарлагын цар хүрээ, магадлалд үндэслэнэ.

3.13.26. Ажлын байрны хяналт, мониторингийн дүн, зөрчлийн талаарх мэдээллийг бичиж, хадгалах бөгөөд ажилтнуудад нээлттэй, үзэх боломжтой байна.

Мэргэжлийн шарлагын тунг үнэлэх

3.13.27. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажилтнуудын мэргэжлийн шарлагын хувийн тунг үнэлэх, дүнг бичиж хадгалах, мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн үзлэгт хамруулах үүрэгтэй.

3.13.28. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажилтнуудын мэргэжлийн шарлагын тунг үнэлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах ба хувийн тунгийн хяналтад хамруулахдаа чанарын удирдлагын систем бүхий зөвшөөрөгдсөн эсвэл итгэмжлэгдсэн дозиметрийн хяналт, хэмжилтэд хамруулна.

3.13.29. Хяналтын бүсэд ажилладаг ажилтнууд, хяналтын бүсэд хааяа ажиллаж тодорхой тун авч буй ажилтнууд мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамрагдана. Хувийн тунгийн хяналт нь тохиромжтой, хүрэлцээтэй, үр дүнтэй байх ёстой.

3.13.30. Хэрэв мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналт тохиромжгүй, хүрэлцээгүй, үр дүнгүй байвал шарлагын хугацаа, зай, байрлалын мэдээлэл, ажлын байрны хяналт, мониторингийн дүнг үндэслэн мэргэжлийн шарлагыг үнэлнэ.

3.13.31. Ажиглалтын бүсэд ажиллаж буй ажилтнууд, хяналтын бүсэд хааяа ордог ажилтнуудын мэргэжлийн шарлагын хувийн тунг ажлын байрны хяналт, мониторинг эсвэл мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтын дүнг үндэслэн үнэлнэ.

3.13.32. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн бохирдлоос шарлагад өртөх ажилтнууд, амьсгалын

системийг хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатай ажилтнууд болон ажлын байрыг ялгаж тогтоосон байна. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хүний биеийн дотор орох цацраг идэвхт цөмүүдийн идэвх, бүтэн биеийн авах цацрагийн тунг буюу эффектив тунг үнэлж, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хяналт мониторингийг зохион байгуулна.

Мэргэжлийн шарлагын тунг баримтжуулах, хадгалах

3.13.33. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажилтан бүрийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн дүн мэдээг баримтжуулан хадгална.

3.13.34. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд, мэргэжлийн шарлагын хувийн тунг тодорхойлох үйлчилгээ үзүүлж буй дозиметрийн үйлчилгээний байгууллага нь ажилтнуудын мэргэжлийн шарлагын тунг ажилтнуудын ажиллаж байх хугацааны туршид болон цацрагтай ажиллахаа больсноос хойш 30 жилийн турш хадгална.

3.13.35. Энэхүү хадгалах баримт бичиг нь дараах зүйлийг агуулна. Үүнд:

1. Ажилтны ажиллаж байсан болон ажиллаж байгаа мэргэжлийн шарлага өгөх ажлын байрны ерөнхий мэдээлэл;
2. Дотоод болон гадаад шарлагаас авсан тунгийн мэдээлэл, мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтын дүн;
3. Өмнө ажиллаж байсан ажлын байрны мэдээлэл, тэнд ажиллаж байхдаа авсан тунгийн мэдээлэл;
4. Осол, зөрчил, хэвийн бус үйл ажиллагааны үед, түүнийг аюулгүй болгоход авсан гадаад болон дотоод шарлага, тунгийн үнэлгээний мэдээлэл, холбогдох дүн шинжилгээний тайлан.

3.13.36. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ажилтан нь өөрийнхөө мэргэжлийн шарлагын тунгийн мэдээллээ үзэх боломжтой байна.
2. Цацрагтай ажиллагч бүрийн авсан мэргэжлийн шарлагын тунгийн хэмжээг өөрт нь танилцуулна.
3. Хяналтын байгууллага, дотоодын хяналт тавих алба эсвэл цацрагийн дотоод хяналтын ажилтан нь хувийн тунгийн мэдээллийг үзэх боломжтой байна.
4. Цацрагтай ажиллагч нь өөр ажилд шилжиж байгаа бол шинэ ажил олгогчид тухайн ажилтны мэргэжлийн шарлагын тунгийн дүн мэдээллийн хувийг гаргаж өгнө.

3.13.37. Хэрэв цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон ажил олгогч нь цацрагтай холбоотой үйл ажиллагаагаа цаашид хэрэгжүүлэхгүй эсвэл татан буугдсан бол мэргэжлийн шарлагын дүн мэдээлэл, түүний

баримт бичгүүдийг Хяналтын байгууллага болон шинээр ажил олгож буй байгууллагад шилжүүлнэ.

Сургалт, заавар, мэдээлэл

3.13.38. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ажилтнуудыг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалт, заавар, мэдээллээр хангана.

3.13.39. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Ажилтнуудад хэвийн үйл ажиллагаа болон аливаа осол, зөрчил, хэвийн бус үйл ажиллагааны улмаас үүсэх эрүүл мэндийн эрсдэлийн талаар хангалттай мэдээлэл өгч, тэднийг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалт, заавар, мэдээлэл, давтан сургалтаар хангана.
2. Ослын үед хариу арга хэмжээ авах ажилтнуудыг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны тохирох мэдээлэл, заавар, сургалт, давтан сургалтаар хангана.
3. Ажилтнууд тус бүрийн хувьд сургалтад хамрагдсан тухай мэдээллийг баримтжуулан хадгална.

Ажлын нөхцөл

3.13.40. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь ямар нэгэн хөнгөлөлт, нэмэлт олгосноор цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг сулруулах ёсгүй.

3.13.41. Ямар нэгэн нөхөн төлбөр, нэмэгдэл цалин, даатгал, урт амралт, нэмэлт амралт, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж олгох гэх мэт нөхцөлийг бүрдүүлснээр ажиллагчдын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг орлохгүй бөгөөд энэхүү стандартыг биелүүлэхээс чөлөөлөгдөхгүй.

Эмэгтэй ажилтнуудын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах тусгай зохион байгуулалт

3.13.42. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмэгтэй ажилтнуудад зориулсан тусгай зохион байгуулалтын арга хэмжээ авах ба шаардлагатай үед тэдний ураг болон хөхүүл хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна.

3.13.43. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хяналтын бүс болон ажиглалтын бүсэд эсвэл ослын нөхцөл байдлын үед эмэгтэй ажилтнуудыг ажиллуулах бол тэдэнд дараах мэдээллийг өгнө. Үүнд:

1. Жирэмсэн үед цацрагийн шарлагад өртсөнөөс урагт учрах цацрагийн эрсдэл;
2. Эмэгтэй ажилтнууд нь жирэмсэн эсвэл хөхүүл хүүхэдтэй бол энэ тухайгаа ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдэд аль болох хурдан мэдэгдэх ёстой;
3. Цацраг идэвхт бодис хоол боловсруулах системийн замаар биед орсон үед хөхүүл хүүхдийн эрүүл мэндэд учрах эрсдэл.

3.13.44. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй гэдгээ мэдэгдсэн нь түүнийг ажлаас гаргах шалтгаан болох ёсгүй бөгөөд ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь түүнийг хэвийн нөхцөлтэй ажлын байранд шилжүүлэн ажиллуулна. Өөрөөр хэлбэл мэргэжлийн шарлагын нөхцөлийг өөрчилж, хүн амын гишүүнийг хамгаалахтай адил төвшинд хамгаалалт болон аюулгүй ажиллагааны арга хэмжээ авна.

18-аас доош насны дадлагажигч оюутнуудын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах тусгай арга хэмжээ

3.13.45. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь 18 нас хүрээгүй хүнийг мэргэжлийн шарлагын нөхцөл бүхий ажлын байранд ажилд авч ажиллуулахыг хориглоно.

3.13.46. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь 18-аас доош насны дадлагажигч оюутнуудын аюулгүй ажиллагааг хангах, хамгаалах тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.13.47. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд 16-аас доош насны хэнийг ч мэргэжлийн шарлагад өртүүлэхийг хориглоно.

3.13.48. Ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь 18-аас доош насны дадлагажигч оюутнуудыг зөвхөн сургалтын зорилгоор хяналтын бүс болон ажиглалтын бүсэд нэвтрэхийг зөвшөөрнө.

3.14. Хүн амын шарлага

3.14.1. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд хүн амын шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагууд нь 3.1.1, 3.1.2, 3.1.3 дахь заалтад дурдсан үйл ажиллагаанд хамаарна. /Хүн амын шарлага гэж сансрын туяа болон байгалийн цацрагийн дэвсгэр түвшний шарлагаас бусад эх үүсвэрээс хүн амын авч буй шарлагыг хэлнэ/

Хүн амын шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах талаар Хяналтын байгууллагын хүлээх үүрэг

3.14.2. Хяналтын байгууллага нь хүн амын авах цацрагийн тунгийн хэмжээг тунгийн хязгаараас хэтрүүлэхгүй байлгах зорилгоор одоогийн цацрагтай холбоотой үйл ажиллагаа, ирээдүйд нэмэгдэх цацрагтай холбоотой үйл ажиллагаа, цацрагийн үүсгүүр зэргийн үзүүлэлт, хүн амд үзүүлэх нөлөөлөл зэргийг тооцоолон цацрагийн эрсдэлийн болон тунгийн хязгаарлалтын угтыг тогтооно.

3.14.3. Хяналтын байгууллага нь “Цацрагийн аюулгүйн норм”-ын 5 дугаар зүйлд заасан хүн амын авч болох цацрагийн тунгийн хязгаар, 6 дугаар бүлэгт заасан Цацрагийн тунгийн хязгаарлалт, 7 дугаар бүлэгт заасан Гадаргуугийн бохирдлын байж болох хэмжээ, 8 дугаар бүлэгт заасан Радоны норм, 9 дүгээр бүлэгт заасан хүнсний бүтээгдэхүүний цацрагийн аюулгүйн норм, 12 дугаар бүлэгт заасан Нүүрс, барилгын материалыг цацраг идэвхийн хэмжээгээр нь ангилан ашиглах нормыг хэтрүүлэхгүй байх шаардлагуудыг хангуулах үүрэгтэй.

3.14.4. Хяналтын байгууллага нь аливаа шинэ төрлийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгохдоо өргөдөл гаргагчаас тухайн үйл ажиллагааны технологи, загварын талаарх баримт бичгүүдийг гаргуулан авч аюулгүйн үнэлгээ хийнэ. Үүнд хүн амыг цацрагийн шарлагад өртүүлж болзошгүй хүчин зүйлс, цацрагийн тунгийн үнэлгээ, загвар технологийн шалгуур үзүүлэлт, шинж чанар, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны нөхцөлийг хамруулан үнэлнэ.

Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвх бүхий ахуйн хэрэглээний бараа нийлүүлэгчийн үүрэг

3.14.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвх бүхий ахуйн хэрэглээний бараа нийлүүлэгч нь хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа улмаас үүсэх цацрагийн нөлөөллөөс хүн амыг хамгаалах үүрэгтэй.

3.14.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвх бүхий ахуйн хэрэглээний бараа нийлүүлэгч нь хүн амын шарлагын тунгийн хэмжээг аль болох бага байлгахаар үйл ажиллагаа явуулна.

3.14.7. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвх бүхий ахуйн хэрэглээний бараа нийлүүлэгч нь “Цацрагийн аюулгүйн норм”-ын 5 дугаар зүйлд заасан хүн амын авч болох цацрагийн тунгийн хязгаар, 6 дугаар бүлэгт заасан Цацрагийн тунгийн хязгаарлалт, 7 дугаар бүлэгт заасан Гадаргуугийн бохирдлын байж болох хэмжээ, 8 дугаар бүлэгт заасан Радоны норм, 9 дүгээр бүлэгт заасан хүнсний бүтээгдэхүүний цацрагийн аюулгүйн норм, 12 дугаар бүлэгт заасан Нүүрс, барилгын материалыг цацраг идэвхийн хэмжээгээр нь ангилан ашиглах нормыг хэтрүүлэхийг хориглоно.

3.14.8. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвх бүхий ахуйн хэрэглээний бараа нийлүүлэгч болон ашигт малтмалын олборлолт боловсруулалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгж нь загвар гаргах, төлөвлөх, ажиллуулах, ашиглалтаас гаргах, хаах, газар нөхөн сэргээх, хаягдлын менежмент хийх, мөн булшилсны дараах үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт,

аюулгүй ажиллагааг хангах ба шарлагын тунгийн хэмжээг аль болох бага байлгах зарчмыг хэрэгжүүлнэ. Үүний тулд дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

1. Хүн амд шарлага өгч болзошгүй аливаа үйл ажиллагаа, түүний өөрчлөлт;
2. Цацрагийн үүсгүүрийн ашиглалт, түүний үзүүлэлтүүд, аливаа өөрчлөлт;
3. Байгаль орчны нөхцөл, экологийн тэнцвэрийн өөрчлөлт;
4. Шарлагын замууд;
5. Бусад үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлт;
6. Ижил төстэй үйл ажиллагаа, үүсгүүртэй холбоотой тэргүүн туршлага;
7. Үйл ажиллагааны туршид үүсэх цацраг идэвхт хаягдлын хуримтлал, байгаль орчинд нийлүүлэлт;
8. Тунгийн үнэлгээ, түүний үнэмшил.

3.14.9. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөртөө хүн амын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах зохион байгуулалт, үйл ажиллагааг тусгана.
2. Хүн амын авах шарлагын тунгийн хэмжээг аль болох бага байлгах, хүн амын шарлагыг хязгаарлах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ авна.
3. Цацрагийн шарлагын цар хүрээ, магадлалыг харгалзан хүн амын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах эх үүсвэр, тохирох багаж төхөөрөмж, техник хэрэгсэл, үйлчилгээгээр хангах журам, шийдвэртэй байна.
4. Хүн амын шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах, мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах үүрэг бүхий албан хаагч нь давтамжтайгаар сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн байна.
5. Хүн амын шарлагыг үнэлэх багаж хэрэгсэл, арга зүйтэй байна.
6. Хүн амын шарлагын тунг үнэлж, хяналт хэмжилтийн дүнг бичиж баталгаажуулна.
7. Цацрагийн шарлагын цар хүрээ, магадлал, цацрагийн эрсдэлийн хэмжээг харгалзан ослын үеийн бэлэн байдлыг хангах зохион байгуулалт, арга хэмжээ, төлөвлөгөөтэй байна.

Зочлогч

3.14.10. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хяналтын бүсэд хүн амын бүлэгт хамаарах хүн, зочлогч нэвтрэх бол цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны мэдлэгтэй, тус бүсэд нэвтрэх эрх бүхий албан хаагчийг дагалдуулан нэвтрэхийг зөвшөөрнө.
2. Хяналтын бүс болон ажиглалтын бүсэд хүн амын бүлэгт хамаарах хүн, зочлогч нэвтрэхээс өмнө тэдэнд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгнө.

Гадаад шарлагаас хамгаалах

3.14.11.Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хүн амыг цацрагийн гадаад шарлагаас хамгаалах дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр бүхий төхөөрөмжийг шинээр суурилуулах зохион байгуулалт, төлөвлөгөө, өмнө суурилуулсан тоног төхөөрөмжид томоохон хэмжээний өөрчлөлт оруулах бол тэдгээрийг ашиглалтад оруулахаас өмнө Хяналтын байгууллагаар хянуулж, зөвшөөрөл авна.
2. Задгай талбайд ашиглагдах үйлдвэрийн радиограф, зөөврийн цөмийн хэмжүүр гэх мэт цацрагийн үүсгүүр бүхий багаж төхөөрөмжийг ажиллуулах үед хүн амын шарлагыг хязгаарлах, нэвтрэхийг хориглох, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Цацрагийн бохирдлоос хамгаалах

3.14.12. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хүн амыг цацрагийн бохирдлоос хамгаалах дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагаанаас цацрагийн бохирдол тархаахгүй байх технологийн сонголт хийх, загвар гаргах, үйл ажиллагаа явуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
2. Цацрагийн бохирдол бүхий талбайд хүн амын бүлэгт хамаарах хүнийг нэвтрүүлэхгүй байх, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ авна.

Цацраг идэвхт хаягдал ба байгаль орчинд нийлүүлэх хаягдал

3.14.13. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвхт хаягдал үүсгэж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь цацраг идэвхт материалыг байгальд нийлүүлэх, цацраг идэвхт хаягдлын менежмент хийхдээ Хяналтын байгууллагын зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.

Цацраг идэвхт хаягдал

3.14.14. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвхт хаягдал үүсгэж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үүсэн гарах цацраг идэвхт хаягдлын идэвх, эзлэхүүний хэмжээг аль болох бага байлгана.
2. Цацрагтай холбоотой үйл ажиллагаанаас үүсэх цацраг идэвхт хаягдалд “Цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу аюулгүй менежмент хийнэ.
3. Ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагаанаас үүсэх цацраг идэвхт хаягдалд “Хүдрийн олборлолт, боловсруулах үйлдвэрээс үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрэм”-ийн дагуу аюулгүй менежмент хийнэ.
4. Цацраг идэвхт хаягдалд агуулагдах цацраг идэвхт цөм, түүний цацраг идэвх, хагас задралын үе, хаягдлын физик төлөв, химийн төлөв, эзлэхүүн гэх мэт үзүүлэлтүүдийг харгалзан түүний төрөлд тохирох боловсруулалт хийн хадгалах, булшлах зэрэг боломжит менежмент хийнэ.
5. Цацраг идэвхт хаягдлыг цацрагийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн булшлах ба түүний хяналт доор булшлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
6. Үүсэн гарсан цацраг идэвхт хаягдал, түүний хадгалалт, булшлалт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.
7. Цацраг идэвхт хаягдлын менежментийн стратеги, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ба цацрагийн шарлагын хэмжээг зохистой хэмжээний доод төвшинд байлгах боломжит бүх арга хэмжээн авч, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангана.

Байгаль орчинд нийлүүлэгдэх хаягдал

3.14.15.Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвхт хаягдал үүсгэж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь байгаль орчинд хаягдал нийлүүлэхдээ цацрагийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулна.

3.14.16.Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон цацраг идэвхт хаягдал үүсгэж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь байгаль орчинд хаягдал нийлүүлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Байгаль орчинд нийлүүлэх материалын үзүүлэлт, идэвх, байгальд нийлүүлэх цэг, арга зам;
2. Цацраг идэвхт материалыг байгаль орчинд нийлүүлснээр хүн амын шарлагыг ихэсгэж болзошгүй шарлагын замыг тодорхойлох;
3. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн үед энэхүү байгальд нийлүүлсэн материалаас хүн амын авах тунгийн хэмжээг үнэлэх;
4. Байгаль орчинд нөлөөлөх байдал;
5. Дээрх (1-4)-т заасан үзүүлэлтүүдийг тодорхойлон Хяналтын байгууллагад илгээнэ.

3.14.17. Цацраг идэвхт материалыг байгаль орчинд нийлүүлснээс хүн амын авах тунгийн хэмжээ 1 жилд 0.3мЗв-ээс хэтрэхгүй байх ёстой.

Хяналт мониторинг ба бүртгэл

3.14.18. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөртөө хүн амын шарлагын хяналт, мониторинг, түүнийг бүртгэн баримтжуулах зохицуулалтыг тусгасан байна.

3.14.19. Хяналтын байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд болон өргөдөл гаргагчийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хянан баталгаажуулна.
2. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн хүн амын шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулна.
3. Хүн амын шарлагын тунг үнэлнэ.
4. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн ирүүлсэн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны жил бүрийн тайлан, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, үнэлгээ хийнэ.
5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдээс ирүүлсэн мониторингийн дүн, тунгийн үнэлгээ болон өөрийн хяналт мониторингийн дүн зэргийг үндэслэн Хүн амын авч буй нийт тунгийн хэмжээг үнэлнэ. Үүнийг үндэслэн тунгийн хязгаараас хэтэрч буй эсэхийг шалгах бөгөөд Тунгийн хязгаарлалтын утгыг тогтооно.
6. Хүн амын шарлагын тунгийн үнэлгээ, хяналт мониторингийн дүн, цацраг идэвхт материалын байгаль орчинд нийлүүлэлт бүрийн бүртгэлийг хөтлөн баримтжуулахыг шаардана.
7. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны холбогдолтой хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгана.

3.14.20. Хяналтын байгууллага нь хүн амын шарлагын тунгийн үнэлгээ, байгаль орчны хяналт, мониторингийн дүнг олон нийтэд нээлттэй байлгана.

3.14.21. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагааны цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад тохирох “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-т хүн амын шарлагын хяналт, мониторинг болон түүнийг бүртгэн баримтжуулах зохицуулалтыг тусган хэрэгжүүлнэ.
2. Хөтөлбөрт тусгах хүн амын шарлагын хяналт мониторингод дараах үзүүлэлтүүдийг тусгана. Үүнд:

а)Цацрагийн үүсгүүрийн гадаад шарлага;

- б) Байгаль орчинд нийлүүлэгдэх хаягдал;
 - в) Байгалийн цацрагийн төвшин;
 - г) Хүн амын шарлагыг үнэлэхэд шаардлагатай бусад чухал үзүүлэлтүүд;
3. Хүн амын шарлагын хяналт, мониторинг, тунгийн үнэлгээний дүнг бүртгэн баримтжуулна.
 4. Хүн амын шарлагын хяналт, байгаль орчны мониторинг, байгаль орчинд нийлүүлсэн хаягдлын идэвхийн агуулга, хэмжээ, байгууламж болон талбай, түүний хил дэх тунгийн чадал, тунгийн үнэлгээний дүн, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд болон Хяналтын байгууллагын шаардсаны дагуу Хяналтын байгууллагад гаргаж өгнө.
 5. Хүн амын шарлагын зөвшөөрөгдөх тунгийн хязгаар болон тунгийн хязгаарлалтын утгаас хэтэрсэн эсвэл байгаль орчинд нийлүүлэх хаягдлын хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээ, хяналтаас чөлөөлөх төвшнөөс хэтэрсэн тохиолдолд Хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
 6. Байгаль дахь цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга, тунгийн чадал мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд Хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэнэ.
 7. Цацрагийн үүсгүүр, цацрагтай холбоотой үйл ажиллагааны үед осол болон хэвийн бус үйл ажиллагаа үүссэнээс байгаль орчинд цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга, цацрагийн төвшин ихсэх зэрэг болзошгүй ослын үеийн бэлэн байдал, мониторингийн чадавхыг бий болгож хэрэгжүүлнэ.
 8. Хүн амын шарлагын үнэлгээ ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг гүйцэтгэх.
 9. Хүн амын шарлагын тунгийн үнэлгээ, байгаль орчны хяналт, мониторингийн дүнг олон нийтэд нээлттэй байлгана.

Ахуйн хэрэглээний бараа

3.14.22. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь тус бүтээгдэхүүн хяналтаас чөлөөлөгдөх хэмжээнд байгаа эсэхийг үл харгалзан үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангана.

3.14.23. Үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангасан гэдэг нь Хяналтын байгууллагаар тогтоогдоогүй тохиолдолд тус бүтээгдэхүүнийг хэрэглээнд гаргахыг хориглоно.

3.14.24. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний барааг хүн амын хэрэглээнд гаргах хүсэлтийг хүлээн авсан Хяналтын байгууллага дараах арга хэмжээг авна. Үүнд:

1. 3.14.22-3.14.30-д заасан шаардлагуудыг хангасан гэдгийг нотлох баримт бичгүүдийг ирүүлэхийг Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчээс шаардана.
2. Ирүүлсэн материалыг судалж, шаардлагатай үзүүлэлтүүдэд үнэлгээ хийж баталгаажуулна.
3. Ахуйн хэрэглээний барааны эцсийн хэрэглээ нь хяналтаас чөлөөлөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тодорхойлно.
4. Тус ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг хэрэглээнд гаргаж болох эсэх талаар шийдвэр гаргана.

3.14.25. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

1. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний барааг хэрэглээнд гаргахын өмнө Хяналтын байгууллагаас тавьсан шаардлага, нөхцөлийг хангасан байна.
2. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь энэхүү стандарт, Цацрагийн аюулгүйн норм болон холбогдох бусад стандартын шаардлагыг хангасан байна.
3. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний барааг дахин ашиглах, засвар үйлчилгээ хийх, булшлах төлөвлөгөөтэй байх ба Хяналтын байгууллагаар хянуулж, баталгаажуулсан байна.

3.14.26. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний барааг хэрэглэх, тээвэрлэх, тэдгээртэй харьцан ажиллах хэвийн ажиллагаа болон түүнийг буруу хэрэглэх, буруу харьцан ажиллах, осол зэрэг хэвийн бус үйл ажиллагааны аль алинд хүн амын шарлага үүсэх боломжтой тул үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь цацрагийн шарлагын хэмжээг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангана.

3.14.27. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Ахуйн хэрэглээний бараанд ашиглагдах цацраг идэвхт цөмүүд, тэдгээрийн хагас задралын үе, идэвх, цацрагийн төрөл, энерги;
2. Ахуйн хэрэглээний бараанд ашиглагдах цацраг идэвхт материалын физик, химийн төлөв, тэдгээрийн хэвийн болон хэвийн бус үйл ажиллагааны үед тавигдах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагууд;
3. Ахуйн хэрэглээний бараанд агуулагдах цацраг идэвхт материалын агуулга ба хаалт, хамгаалалт, хэвийн болон хэвийн бус үйл ажиллагааны үед цацраг идэвхт материалтай харьцах;
4. Ахуйн хэрэглээний бараанд засвар, үйлчилгээ хийх шаардлага, хэрхэн завсар үйлчилгээ хийх;

5. Ижил төстэй ахуйн хэрэглээний бараатай холбоотой туршлага.

3.14.28. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа бүр дээр үзэгдэхүйц гадарга дээр нь санамж, тэмдэг, холбогдох дараах мэдээллийг тод гаргацтай салж үрэгдэхээргүйгээр байрлуулна. Үүнд:

а) Ахуйн хэрэглээний бараанд агуулагдах цацраг идэвхт материалын агуулга, нэр төрөл, идэвх;

б) Хэрэглээнд гаргахыг зөвшөөрсөн Хяналтын байгууллагын шийдвэр;

в) Дахин ашиглах болон булшлах талаарх шаардлагууд;

2. Дээрх мэдээллүүдийг ахуйн хэрэглээний барааны тээвэрлэлтийн сав баглаа болон жижиглэн худалдааны сав баглааны гадна тод гаргацтай хэвлэн наана.

3.14.29. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь ахуйн хэрэглээний бараа тус бүрийн шаардлагатай заавар, мэдээллээр хангана. Үүнд:

1. Ахуйн хэрэглээний барааг суурилуулах, ашиглах, ажиллуулах заавар;
2. Ахуйн хэрэглээний бараанд засвар үйлчилгээ хийх заавар;
3. Цацраг идэвхт цөмийн нэр төрөл, идэвх, үйлдвэрлэсэн огноо;
4. Хэвийн ажиллагаа болон засвар үйлчилгээний үеийн цацрагийн тунгийн чадал;
5. Дахин ашиглах болон булшлах шаардлагууд ба зөвлөмж.

3.14.30. Цацраг идэвхт ахуйн хэрэглээний бараа үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь тус барааг жижиглэн худалдаалагчдыг тээвэрлэлтийн болон хадгалалтын аюулгүй ажиллагааны заавар, мэдээллээр хангана.

3.15. Эмнэлгийн шарлага

Хамрах хүрээ

3.15.1. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн эмнэлгийн шарлагад зөвшөөрөгдөх тунгийн хязгаар тавигдахгүй./Эмнэлгийн шарлага гэж эмчилгээ, оношилгооны үед авч буй шарлагыг хэлнэ/

Эмнэлгийн шарлагын талаар Хяналтын байгууллагын хүлээх үүрэг

3.15.2. Хяналтын байгууллага нь эмнэлгийн шарлага үүсгэж буй байгууллага зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангуулна.

3.15.3. Хяналтын байгууллага нь оношилгооны цацрагийн тунгийн зөвлөх төвшин, тунгийн хязгаарлалтын утгыг тогтооно. Мөн дотуур шарлагын эмчилгээ оношилгоо хийгдсэн өвчтөнийг эмнэлгээс гаргах шалгуур болон зөвлөмжийг гаргана.

3.15.4. Хяналтын байгууллага нь Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд буюу радиологич эмч, дүрс оношилгооны эмч, шийдвэр гаргаж буй эмч, эмнэлгийн физикч, рентген техникч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер болон цацрагтай холбоотой үйл ажиллагаанд оролцож буй бусад эмч ажилтнууд энэхүү дүрэм, Цацрагийн аюулгүйн норм, цацрагийн хамгаалалтын бусад дүрэм, стандартыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагуудыг хангуулна.

Эмнэлгийн шарлагын талаар цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн хүлээх үүрэг

3.15.5. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь үндэслэлгүйгээр хэн нэгнийг эмнэлгийн шарлагад өртүүлэхийг хориглоно.

3.15.6. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн эмнэлгийн шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангана.

3.15.7. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагаар оношилгоо, эмчилгээ хийлгэх хүнд эмнэлгийн шарлагын ач тус болон эрсдэлийн талаар тохирох мэдээллийг өгнө.

3.15.8. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь өвчтөнд шинж тэмдэг илэрсэн болон илрээгүй аль ч тохиолдолд дараах нөхцөлийг хангалгүйгээр эмнэлгийн шарлагад өртүүлж болохгүй. Үүнд

1. Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний хөтөлбөртэй байх ба цацрагийн оношилгоо эмчилгээ хийлгэх шийдвэр нь энэхүү хөтөлбөрт нийцсэн байна.
2. Цацрагийн оношилгоо, эмчилгээ хийх тухай эмчийн шийдвэр болон өвчний түүх, мэдээллийг үндэслэсэн байна.
3. Эмнэлгийн шарлагын үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг радиологич эмч болон оношилгоо эмчилгээ хийлгэх шийдвэр гаргаж буй эмч нарын зөвлөлдсөний дагуу хангана.
4. Цацрагийн оношилгоо эмчилгээнд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангана.
5. Цацрагийн оношилгоо эсвэл эмчилгээ хийлгэх өвчтөн болон өвчтөний хууль ёсны асран хамгаалагчид цацрагийн оношилгоо, эмчилгээний талаарх мэдээлэл, түүний ач тус болон эрсдэлийн талаар тохирох мэдээллийг өгнө.

3.15.9. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь хэн нэгнийг судалгааны зорилгоор эмнэлгийн шарлагад өртүүлж болохгүй.

3.15.10. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь өвчтөний асран хамгаалагчийг эмнэлгийн шарлагад өртүүлэхийг хориглох бөгөөд зөвхөн зайлшгүй тохиолдолд, тэдэнд эмнэлгийн цацрагийн шарлагын үеийн цацрагийн хамгаалалт, цацрагийн эрсдэлийн талаарх холбогдох мэдээллийг өгч ойлгуулсан тохиолдолд л тэднийг шарлагад өртүүлэхийг зөвшөөрнө.

3.15.11. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь өвчтөний асран хамгаалагчийг эмнэлгийн шарлагад өртүүлэх тохиолдолд тэдний авах цацрагийн тунг аль болох бага байлгах боломжтой бүх арга хэмжээг авна.

3.15.12. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Цацрагийн оношилгоо, эмчилгээг төлөвлөх ба гүйцэтгэхэд өвчтөний цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааг хангах ба цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг эмнэлгийн радиологич эмч, эмнэлгийн физикч, эмнэлгийн цацрагийн техникч нар хамтран гүйцэтгэнэ.
2. Эмнэлгийн радиологич эмч, эмнэлгийн физикч, цацрагийн техникч, эмчлэгч эмч нар нь өвчтөний цацрагийн оношилгоо, эмчилгээний үед цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагааг тусгай зориулалтын өрөөнд гүйцэтгэнэ.
3. Эрүүл мэндийн асуудал хариуцсан хяналт, зохицуулалтын байгууллагаас заасан хүрэлцэхүйц тооны эмч, бага эмч, асрагч, сувилагч, физикч, техникчтэй байна.
4. Цацрагийн эмчилгээнд ашиглаж буй тоног төхөөрөмжүүд нь чанарын хяналтад, баталгаажилтад хамрагдсан байх ба чанарын хяналтын багаж, дозиметрүүд нь тохируулга баталгаажилтад хамрагдсан байна.
5. Цацрагийн эмчилгээнд ашиглаж буй тоног төхөөрөмжүүдэд стандартын дагуу чанарын хяналт, баталгаажилт хийлгэх ба чанарын хяналтын багаж, дозиметрүүд нь тохируулга баталгаажилтад хамруулах үйл ажиллагааг эмнэлгийн физикч хариуцан гүйцэтгэнэ.
6. Цацрагийн оношилгоонд ашиглаж буй тоног төхөөрөмжүүдэд стандартын дагуу чанарын хяналт, баталгаажилт хийлгэх ба чанарын хяналтын багаж, дозиметрүүдийг тохируулга баталгаажилтад хамруулна. Үүнийг эмнэлгийн физикч хариуцан гүйцэтгэнэ.
7. Дээрх үйл ажиллагаанд оролцогч талуудын төлөөллийг баримтжуулна.

Эмнэлгийн шарлагад үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангах

3.15.13. Эмнэлгийн шарлагад оролцогч талууд үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг баримтална.

3.15.14. Цацрагийн оношилгоо болон эмчилгээний ашиг тус болон учирч болзошгүй цацрагийн эрсдэлийг харьцуулан үзэх ба цацрагийн бус эмчилгээний арга техник,

технологийг ашиглах боломж байгаа эсэхийг харгалзан эмнэлгийн шарлага үндэслэлтэй байгаа эсэхийг тогтооно.

3.15.15. Цацрагийн оношилгоо болон эмчилгээ нь үндэслэлтэй байгаа эсэхийг Эрүүл мэндийн асуудал хариуцсан хяналт, зохицуулалтын байгууллага ба цацрагийн тунгийн үнэлгээний мэргэшлийн байгууллага эсвэл мэргэшсэн этгээдтэй хэлэлцэн тогтоох ба байнга хянан үзэж дэвшилтэт техник, технологи нэвтэрсэн эсэхийг харгалзан шинэчилж байна.

3.15.16. Тухайн нэг өвчтөний хувьд эмнэлгийн шарлагын үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангахад эмнэлгийн радиологич эмч, эмчлэгч эмч зөвлөлдөх ба доорх асуудлаар хэлэлцэнэ, хэрэв өвчтөн нь жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй бол түүнийг оролцуулан тусгай зөвлөгөөн хийнэ. Үүнд:

1. Цацрагийн оношилгоо эмчилгээ хийлгэх хүсэлт нь тохирсон эсэх;
2. Цацрагийн оношилгоо эмчилгээ нэн яаралтай хийлгэх хэрэгтэй байгаа эсэх;
3. Эмнэлгийн шарлагын үзүүлэлтүүд;
4. Тухайн өвчтөний үзүүлэлтүүд;
5. Өвчтөний цацрагийн оношилгоо, эмчилгээ хийлгэж байсан тухай өмнөх мэдээлэл.

3.15.17. Тухайн нэг өвчтөний хувьд эмнэлгийн шарлагын үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангахад олон улсын болон үндэсний холбогдох зөвлөмжийг дагана.

3.15.18. Урьдчилан сэргийлэх зорилгоор цацрагийн оношилгоонд хүн амыг хамруулахад үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангах нь оношилгоо эмчилгээний хөтөлбөрийн нэг хэсэг байх ба түүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн хяналт, зохицуулалтын байгууллага болон цацрагийн тунгийн үнэлгээний мэргэшсэн байгууллага болон мэргэшсэн этгээдийн хамтын ажиллагаагаар гүйцэтгэнэ.

3.15.19. Оношилгоо эмчилгээний хөтөлбөрт хамрагдаагүй боловч, өвчнийг эрт үед илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлгийн шарлагад өртөх өвчтөний хувьд эрүүл мэндийн асуудалд хариуцсан хяналт зохицуулалтын байгууллага болон тунгийн үнэлгээний мэргэшсэн байгууллагын зөвлөмжийн дагуу эмнэлгийн радиологич эмч болон эмчлэгч эмч үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангуулна. Тус өвчтөнд цацрагийн шарлагын аюул эрсдэл, мөн цацрагийн оношилгооныашиг тусын талаар мэдээлэл өгсөн байна.

Цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах

3.15.20. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах аргаар цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Загвар гаргах

3.15.21. Эмнэлгийн шарлагын тоног төхөөрөмж, программ хангамж нь Олон улсын цахилгаан техникийн комисс ба Олон улсын стандартчиллын байгууллагын стандарт болон үндэсний холбогдох стандартад нийцсэн байна.

Үйл ажиллагаа

3.15.22.Цацрагийн оношилгоо буюу ионжуулагч цацраг ашиглан дүрсээр харан эмчилгээ хийхэд радиологич эмч эмнэлгийн цацрагийн технологич болон эмнэлгийн физикчтэй шаардлагатай бол радиохимич, цацрагийн эм зүйчтэй хамтран дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Цацрагийн оношилгоонд тохирох тоног төхөөрөмж, программ хангамж ашиглах, цөмийн онош зүйд тохирох цацраг идэвхт эм тариа ашиглана.
2. Эмнэлгийн зориулалтаар үр дүнтэй цацрагийн оношилгоо хийхэд шаардагдах эмнэлгийн шарлагыг хамгийн бага байлгах үзүүлэлт, техникийг сонгоно. Ингэхдээ эмнэлгийн шарлагын зөвлөх төвшин болон дүрс оношилгооны чанарын шаардлагыг хангасан байна.

3.15.23. Цацрагийн эмчилгээ хийхэд радиологич эмч эмнэлгийн цацрагийн технологич болон эмнэлгийн физикчтэй хамтран өвчтөн бүрийн цацрагаар шарахаар төлөвлөсөн хэсэгт төлөвлөсөн тунг тухайн эрхтний тэсвэрлэх хэмжээнд өгч бусад хэсгийн авах тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.15.24. Цацраг идэвхт эм тариагаар эмчилгээ хийхэд радиологич эмч эмнэлгийн цацрагийн технологич болон эмнэлгийн физикчтэй хамтран шаардлагатай бол радиохимич, цацрагийн эм зүйчтэй хамтран өвчтөн бүрд тохирох цацраг идэвх бүхий эм тариаг сонгож, зөвхөн төлөвлөсөн хэсэгт байрлуулах ба биеийн бусад хэсгийн авах цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.15.25. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг дараах хүмүүст зориулж тусгай арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Эмнэлгийн шарлага хийлгэх хүүхдүүд;
2. Урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн үзлэгийн хөтөлбөрт хамрагдсан хүмүүс;
3. Харьцангуй өндөр тун авах өвчтөн;
4. Эмнэлгийн шарлага хийлгэх жирэмсэн эмэгтэй;
5. Цацраг идэвхт эм болон тариагаар эмчилгээ хийлгэх хөхүүл хүүхэдтэй эхчүүд.

Тохируулга

3.15.26. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Эмнэлгийн шарлага үүсгэх бүх үүсгүүр, багаж төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандартын дагуу тохируулга, баталгаажилт хийгдсэн байна.
2. Тохируулга баталгаажуулалтыг стандартад заасан хугацаанд болон Хяналтын байгууллагаас тогтоосон хугацаанд мөн багаж төхөөрөмжийг ашиглалтад оруулахын өмнө болон тунгийн хэмжээнд нөлөөлөхүйц засвар үйлчилгээний дараа хийж гүйцэтгэнэ.
3. Туяа эмчилгээний багаж төхөөрөмжийг ашиглалтад оруулахын өмнө зөвшөөрөгдсөн байгууллагаар тохируулга, баталгаажуулалт хийлгэнэ.
4. Өвчтөний тунгийн хэмжилтийн дозиметр нь тохируулга баталгаажуулалт хийгдсэн байна.
5. Тохируулгын үүсгүүр нь Дозиметрийн тохируулга баталгаажуулалтын лабораториор баталгаажсан байна.

Өвчтөний тунг хэмжих дозиметр

3.15.27. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь өвчтөний тунгийн хэмжээг хянах дозиметрээр хангах ба эмнэлгийн физикч нь өвчтөний тунгийн хэмжээг хэмжиж хянан баримтжуулна.

3.15.28. Дозиметр нь тохируулга баталгаажилт хийгдсэн байх ба дараах үзүүлэлтүүдийг тодорхойлоход ашиглагдана. Үүнд:

1. Цацрагийн оношилгоо хийлгэсэн өвчтөний тун;
2. Ионжуулагч цацраг ашиглан дүрсээр харан эмчилгээ хийлгэсэн өвчтөний тун;
3. Зайн туяа эмчилгээ болон дотуур туяа эмчилгээ хийлгэсэн өвчтөний төлөвлөгдсөн эзлэхүүнд шингэсэн тун болон холбогдох эд эрхтэнд шингэсэн тун;
4. Задгай үүсгүүрээр эмчилгээ хийлгэсэн өвчтөнд шингэсэн тун.

Цацрагийн оношилгоо хийхэд тунгийн зөвлөх төвшин

3.15.29. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Цацрагийн оношилгоо хийхэд “Цацрагийн аюулгүйн норм”-ийн 13 дугаар зүйлд заасан цацрагийн тунгийн болон идэвхийн зөвлөх төвшинг баримтална.

2. Цацрагийн оношилгоо хийхэд “Цацрагийн аюулгүйн норм”-ийн 13 дугаар зүйлд заасан цацрагийн тунгийн болон идэвхийн зөвлөх төвшнөөс хэтэрч байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.
3. Өвчтөний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа нь тохирсон эсэхийг хянан үзнэ.
4. Өвчтөнд өгч буй тун эсвэл идэвхийн хэмжээ нь зөвлөх төвшнөөс хэтэрсэн бол цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг сайжруулах, эмнэлгийн шарлагын үйл ажиллагааг залруулах арга хэмжээ авна.
5. Өвчтөнд өгч буй тун эсвэл идэвхийн хэмжээ зөвлөх төвшнөөс бага бөгөөд оношилгооны хангалттай мэдээллийг өгөхгүй байвал эсвэл өвчтөнд ямар нэгэн ач тусгүй байвал цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангаж, эмнэлгийн шарлагын үйл ажиллагааг залруулах арга хэмжээ авна.

Эмнэлгийн шарлагын чанарын баталгаа, чанарын хяналт

3.15.30. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь удирдлагын буюу менежментийн системд эмнэлгийн шарлагын чанарын баталгааны иж бүрэн хөтөлбөрийг хамруулан бий болгоно.

3.15.31. Энэхүү хөтөлбөрт радиологич эмч, эмнэлгийн цацрагийн технологич, эмнэлгийн физикчийн идэвхтэй оролцоог хангах ба цөмийн онош зүйн хувьд радиохимич ба цацрагийн эм зүйчийг хамруулна.

3.15.32. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад олон улсын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон зарчмыг хангана.

3.15.33. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын чанарын баталгааны иж бүрэн хөтөлбөрт дараах арга хэмжээг хамруулна. Үүнд:

1. Цацраг үүсгэгч тоног төхөөрөмжийн физик үзүүлэлтүүдийг хэмжинэ.
2. Эмнэлгийн физикч нь дараах хугацаанд хэмжиж хянана. Үүнд:
 - а) Цацраг үүсгэгч тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулахын өмнө;
 - б) Ашиглалтын хугацаанд тодорхой давтамжтайгаар;
 - в) Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц засвар үйлчилгээний дараа;
 - г) Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц программ хангамжийг шинээр суурилуулах, программ хангамжийг шинэчлэн өөрчилсний дараа;

3. Хэрэв физик үзүүлэлтүүд нь заагдсан хэмжээнээс зөрөөтэй байвал тэдгээрийг залруулах арга хэмжээг гүйцэтгэнэ.
4. Цацрагийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн физикийн болон эмнэлгийн үзүүлэлтүүдийг олон улсын болон үндэсний стандартын дагуу баталгаажуулна.
5. Холбогдох үйл ажиллагаа болон засвар үйлчилгээ, үр дүнг баримтжуулан хадгална.
6. Дозиметрийн болон бусад хэмжилтийн багажуудын хэвийн ажиллагааг шалгаж, тохируулга баталгаажуулалтад хамруулна.

3.15.34. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын чанарын баталгааны иж бүрэн хөтөлбөр, түүний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийлгэж болох бөгөөд түүний давтамж нь цацрагтай оношилгоо эсвэл эмчилгээний үйл ажиллагаа болон холбогдох эрсдэлээс хамаарна.

Эмнэлгийн шарлагад өртөх жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах

3.15.35. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийг эмнэлгийн шарлагад өртүүлэхэд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах тусгай арга хэмжээг авсан байна.

3.15.36. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн хүлээлгийн өрөө, нийтийн өрөө тасалгаанд цацрагийн оношилгоо хийлгэх эмэгтэйчүүд нь жирэмсэн байж магадгүй эсвэл цөмийн онош зүйн оношилгоо, эмчилгээнд хамрагдах эмэгтэйчүүд нь хөхүүл хүүхэдтэй бол энэ тухайгаа радиологич эмч, эмнэлгийн цацрагийн технологич ба бусад ажилтнуудад мэдэгдэх шаардлагатай тухай анхааруулга, санамжуудыг байрлуулсан байна.

3.15.37. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь нөхөн үржих насны эмэгтэй өвчтөнүүдэд цацрагийн оношилгоо хийхийн өмнө жирэмсний байдлын талаар тодруулж, үндэслэлтэй байх, цацрагийн тунг аль болох багасгах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ авах журамтай байна.

3.15.38. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмэгтэй өвчтөнүүдэд цацраг идэвхт эм тариа ашиглан оношилгоо хийхийн өмнө хөхүүл хүүхэдтэй эсэх талаар тодруулж, үндэслэлтэй байх, цацрагийн тунг аль болох багасгах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ авах журамтай байна.

Цацраг идэвхт изотопоор эмчилгээ хийлгэсэн өвчтөнийг эмнэлгээс гаргах

3.15.39. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацраг идэвхт изотопоор эмчилгээ хийлгэсэн өвчтөнийг эмнэлгээс гаргахын өмнө түүний гэр бүлийн гишүүд болон түүнд ойрхон байх бусад хүмүүсийн цацрагийн хамгаалалтыг хангах зохион байгуулалтын арга хэмжээг бий болгосон байна.

3.15.40. Радиологич эмч нь битүү эсвэл задгай цацраг идэвхт изотопоор эмчилгээ хийлгэсэн өвчтөнийг эмнэлгээс гаргахын өмнө эмнэлгийн физикч болон эмнэлгийн цацрагийн хамгаалалтын ажилтнаар өвчтөний бие дэх цацраг идэвхт изотопын идэвхийн зөвлөх төвшин болон өвчтөнөөс 1м-ийн зай дахь тунгийн чадлыг тодорхойлуулж баталгаажуулсны дараа эмнэлгээс гаргахыг зөвшөөрнө.

3.15.41. Радиологич эмч нь битүү эсвэл задгай цацраг идэвхт изотопоор эмчилгээ хийлгэсэн өвчтөнийг эмнэлгээс гаргахын өмнө түүнд эсвэл түүний асран хамгаалагчид цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зааврыг бичгээр өгөх бөгөөд өвчтөний ойр байх хүмүүсийн авах цацрагийн тунг аль болох бага байлгах, цацрагийн бохирдол тархаахгүй байх, цацрагийн эрсдэлийн талаар зааварчилгааг өгнө.

Эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл

3.15.42. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдал үүсэх магадлалыг багасгах боломжтой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

3.15.43. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдалд шуурхай шинжилгээ хийж, боломжтой бол залруулах арга хэмжээ авна.

3.15.44. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь цацраг үүсгэгч тоног төхөөрөмжийн загварын дутагдалтай байдал, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны алдаа, программ хангамжийн алдаа, хүний алдаанаас шалтгаалан үүсэх эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдал үүсэх магадлалыг багасгах боломжтой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөлийн дүн шинжилгээ

3.15.45. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдал үүссэн бол дүн шинжилгээний арга хэмжээг шуурхай гүйцэтгэнэ. Үүнд:

1. Цацрагийн эмчилгээг радиологич эмчийн төлөвлөснөөс өөр өвчтөнд хийсэн, өвчтөний төлөвлөгдсөн эд эрхтнээс өөр эрхтэнд хийсэн, төлөвлөснөөс өөр цацраг идэвхт эм тариа ашигласан, буруу идэвх, буруу тун өгсөн;
2. Хоёрдогч ноцтой нөлөөлөл үүсгэх бусад тохиолдлууд;
3. Цацрагийн оношилгоо эсвэл ионжуулагч цацраг ашиглан дүрсээр харан эмчлэх ажиллагааг буруу өвчтөн, буруу эд эрхтэнд хийсэн;

4. Ионжуулагч цацраг ашиглан дүрсээр харан эмчилгээ хийхдээ төлөвлөснөөс их тун өгсөн;
5. Цацрагийн оношилгоо, эмчилгээний үед санаандгүй байдлаар ураг эсвэл үр хөврөлийг шарлагад өртүүлсэн;
6. Цацраг үүсгэгч тоног төхөөрөмжийн ямар нэгэн алдаа, программ хангамжийн алдаа, осол зэргээс шалтгаалан эмнэлгийн шарлага өгсөн өвчтөнд төсөөлж байснаас өөр, аюултай, хэвийн бус байдал үүссэн.

3.15.46. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдал үүссэн бол дараах дүн шинжилгээг хийнэ. Үүнд:

1. Өвчтөнд өгсөн болон өвчтөний авсан тунг тооцоолно.
2. Эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдал дахин үүсэхээс сэргийлэх засаж залруулах арга хэмжээг тогтооно.
3. Бүх залруулах, засах арга хэмжээг гүйцэтгэнэ.
4. Дээрх дүн шинжилгээг гүйцэтгэсний дараа эсвэл хяналтын байгууллагын шаардсаны дагуу аль болох хурдан тэмдэглэн баримтжуулна.
5. Эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдлын талаарх мэдээлэл эсвэл хяналтын байгууллагын шаардсан бусад мэдээллийг аль болох хурдан гаргаж өгнө.
6. Эмнэлгийн радиологич эмч нь өвчтөнийг эмчлэгч эмч, өвчтөн эсвэл түүний асран хамгаалагчид эмнэлгийн шарлагын төлөвлөгдөөгүй буюу ослын нөхцөл байдлын талаар тохирох мэдээллийг өгнө.
7. Ослын талаар холбогдох хяналтын байгууллагад мэдээлнэ.

Хянан баталгаажуулах ба баримтжуулах

3.15.47. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлага үүсгэх байгууламж болон үйл ажиллагаандаа цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг тодорхой давтамжтайгаар хянан шалгаж, баталгаажуулна.

Цацрагийн хяналт, шалгалт

3.15.48. Радиологич эмч, эмнэлгийн цацрагийн технологич болон эмнэлгийн физикч нар эмнэлгийн шарлага үүсгэх байгууламж болон үйл ажиллагаандаа цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг давтамжтайгаар хянан үзэж, баталгаажуулна.

3.15.49. Эмнэлгийн шарлага үүсгэх байгууламжид гүйцэтгэж буй цацрагтай холбоотой үйл ажиллагаанд үндэслэлтэй байх, цацрагийн тунг аль болох бага байлгах цацрагийн хамгаалалтын зарчмыг хэрхэн хангаж буйг дахин хянан үзэж, дүн шинжилгээ хийнэ.

Бүртгэн баримтжуулах

3.15.50. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дараах хувийн баримтуудыг бий болгож хяналтын байгууллагын заасан хугацааны туршид хадгална. Үүнд:

1. Радиологич эмч, эмнэлгийн цацрагийн технологич, эмнэлгийн физикч, цацрагийн эм зүйч, эмчлэгч эмч зэрэг үүрэг хариуцлага бүхий албан тушаалтнуудын бүртгэл;
2. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалтын мэдээлэл, бүртгэл.

3.15.51. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь дозиметр, баталгаажуулалт, чанарын баталгааны хөтөлбөртэй хамааралтай дараах баримтуудыг бий болгож, хяналтын байгууллагын заасан хугацааны туршид хадгална. Үүнд:

1. Өвчтөний эмчилгээний явцад төлөвлөгдсөн физикийн болон эмнэлгийн хэмжигдэхүүнүүдийн тохируулга, тэдгээрийн давтамжтай үзлэгийн дүн бүртгэл;
2. Өвчтөний тунгийн хэмжээний дүн бүртгэл;
3. Цацрагийн оношилгооны тунгийн үнэлгээний дүн бүртгэл;
4. Эмнэлгийн шарлагын чанарын баталгааны иж бүрэн хөтөлбөрт тусгагдсан дүн бүртгэл.

3.15.52. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь эмнэлгийн шарлагын дараах бүртгэлийг бий болгож, хяналтын байгууллагын заасан хугацаанд хадгална. Үүнд:

1. Цацрагийн оношилгооны шарлагын тоо, тунгийн үнэлгээнд шаардагдах мэдээлэл, флюороскопийн шарлагын хугацаа;
2. Ионжуулагч цацраг ашиглан дүрсээр харан эмчлэх эмчилгээний шарлагын тоо, тунгийн үнэлгээнд шаардагдах мэдээлэл, флюороскопийн шарлагын хугацаа, дүрсийн тоо;
3. Цөмийн онош зүйд хэрэглэсэн цацраг идэвхт эм тарианы төрөл, тэдгээрийн идэвх;
4. Цацрагийн гадаад шарлагын болон дотуур шарлагын эмчилгээний шарахаар төлөвлөсөн эзлэхүүний тодорхойлолт, төлөвлөсөн эзлэхүүний төвд шингэсэн тун, төлөвлөсөн эзлэхүүнд шингэсэн хамгийн их болон бага тун, эсвэл төлөвлөсөн эзлэхүүнд шингэсэн тунтай дүйцэхүйц мэдээлэл, радиологич эмчийн тодорхойлсон эд, эрхтэнд шингэсэн тун;
5. Эмнэлгийн шарлагын ослын болон хэвийн бус нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан.

Дөрөв. Ослын шарлагын нөхцөлд

цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг

хангах шаардлагууд

4.1. Хамрах хүрээ

4.1.1. Цөмийн болон цацрагийн ослын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны шаардлагуудыг тогтооно.

4.2. Ерөнхий шаардлагууд

Ослын үеийн бэлэн байдлын менежментийн систем

4.2.1. Төрийн эрх бүхий байгууллага нь ослын үеийн бэлэн байдлын менежментийн системийг байгуулж, хэрэгжүүлнэ.

4.2.2. Төрийн эрх бүхий байгууллага нь улсын хэмжээнд цөмийн болон цацрагийн ослоос хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах хариу арга хэмжээ авахын тулд ослын үеийн бэлэн байдлын менежментийн системийг байгуулж, хэрэгжүүлнэ.

4.2.3. Ослын үеийн бэлэн байдлын менежментийн систем нь аюул ослын үнэлгээний дүнг үндэслэн боловсруулагдсан байна. Энэ систем нь цацрагтай холбоотой үйл ажиллагаа ба байгууламжтай холбоотой осол, бага магадлалтай ослын тохиолдолд ч гэсэн үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжтой байна.

4.2.4. Цөмийн болон цацрагийн ослын үеийн бэлэн байдлын менежментийн систем нь бусад төрлийн аюул ослын үеийн бэлэн байдлын менежментийн системтэй уялдсан байна.

4.2.5. Ослын үеийн бэлэн байдлын менежментийн систем нь бүсийн, үндэсний, олон улсын төвшинд дараах үндсэн элементүүдийг агуулсан байна. Үүнд:

1. Аюулын үнэлгээ хийнэ.
2. Ослын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж, ослын үед хариу арга хэмжээ авах дасгал сургуулилт хийнэ.
3. Ослын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах байгууллага, хүмүүсийн үүргийг тодорхой хуваарилна.
4. Байгууллага хоорондын харилцан хамтын ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулна.
5. Мэдээлэл дамжуулах найдвартай харилцаа холбооны хэрэгсэлтэй байна.
6. Хүн амд мэдээлэл хүргэнэ.
7. Ослын нөлөөнд өртөж болзошгүй хүн ам, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх болон цуцлах хамгаалалтын стратегитай байна.
8. Ослын үед үүрэг гүйцэтгэх ажилтнууд, онцгой байдлын ажилтнуудыг хамгаалах зохион байгуулалттай байна.

9. Ослын үед үүрэг гүйцэтгэх ажилтнууд, онцгой байдлын ажилтнуудыг боловсрол, сургалтаар хангаж, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулна.
10. Ослын шарлагын нөхцөлөөс үүсэж тогтсон шарлагын нөхцөл рүү шилжих бэлтгэл ажлыг хангана.
11. Ослын үед хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ хийх ажлыг зохион байгуулна.
12. Хувь хүний болон байгаль орчны цацрагийн хэмжилт шинжилгээ хийж, тунгийн үнэлгээ хийнэ.
13. Шаардлагатай болон сонирхогч талуудыг оролцуулна.

4.2.6. Төрийн эрх бүхий байгууллага нь олон улсын ослын үеийн бэлэн байдлын зохион байгуулалтыг зохицуулна.

4.3. Хүн амын шарлага

Ослын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах

4.3.1. Төрийн эрх бүхий байгууллага нь үндэслэлтэй байх, шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах зарчмыг хангуулж, хамгаалалтын стратегийг урьдчилан боловсруулсан байна. Энэ нь ослын үед нэн яаралтай хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.

4.3.2. Төрийн эрх бүхий байгууллага нь үндэслэлтэй байх, шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод төвшинд байлгах зарчмыг хангуулж, хамгаалалтын стратегийг аюул ослын үнэлгээнд үндэслэн урьдчилан боловсруулж хүн амд учирч болзошгүй стохастик эффектийн магадлалыг багасгах ба детерминистик эффектээс сэргийлнэ. / *Стохастик эффект гэж Цацрагийн бага тунгийн үйлчлэлээр удаан хугацаанд хүний эрүүл мэндэд үүсэх хавдар гэх мэт сөрөг нөлөөлөл /босго тунгүй/-ийг хэлнэ. Детерминистик эффект гэж Цацрагийн их тунгийн үйлчлэлээр хүний эрүүл мэндэд богино хугацаанд үүсэх ноцтой сөрөг нөлөөлөл /босго тунтай/-ийг хэлнэ/*

4.3.3. Хамгаалалтын стратеги нь дараах заалтуудыг заавал агуулсан байна. Үүнд:

1. Бүх шарлагын замуудыг тооцож, ослын үед авах эффектив тунгийн зөвлөх төвшинг 20-100мЗв-ийн хооронд тогтооно. Хамгаалалтын стратегийг ослын үед авах эффектив тунг энэхүү зөвлөх төвшнөөс бага байлгах аргаар боловсруулж төлөвлөнө.
2. Хамгаалалтын стратегийн төлөвлөлтийг үндэслэн ослын үед хүлээн авах тун болон хүлээн авсан тунгаас хамааруулан хамгаалалтын арга хэмжээ болон хариу авах арга хэмжээний ерөнхий шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргана. Шалгуур үзүүлэлтүүдийн тоон утгууд нь заасан утгаас хэтэрвэл хамгаалалтын арга хэмжээ болон хариу арга хэмжээг гүйцэтгэнэ.
3. Хамгаалалтын стратеги болон ерөнхий шалгуур үзүүлэлт тогтоогдсон бол ослын нөхцөл байдлын тохиолдол бүрд гүйцэтгэх үйл ажиллагааг урьдчилан боловсруулна. Ослын үед хариу арга хэмжээ авах, гүйцэтгэх үйл ажиллагааны шалгуур нь ослын нөхцөл, үзүүлэлтүүдээс хамаарна.

4.3.4 Хамгаалалтын арга хэмжээ бүр нь үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангасан байх ба хамгаалалтын стратегид тусгагдсан байна.

4.3.5. Төрийн эрх бүхий байгууллага нь ослын динамик үзүүлэлтийг харгалзан ослын бэлэн байдал болон хариу арга хэмжээг зохион байгуулна. Ослын үед хариу арга хэмжээ авах анхны үйл ажиллагаа, шийдвэр нь дараа дараагийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх ба газарзүйн байрлал, нөхцөл байдал зэргээс хамааран хариу арга хэмжээний шаардлагууд харилцан адилгүй байна.

4.3.6. Ослын шарлагын нөхцөлийн үед хариу арга хэмжээг нэн яаралтай гүйцэтгэхэд дараах арга хэмжээг заавал гүйцэтгэнэ. Үүнд:

1. Ослын үеийн нөхцөл байдалд үндэслэн их хэмжээний детерминистик нөлөөлөл үүсэхээс сэргийлэх хамгаалалтын болон хариу арга хэмжээ авна. Болж өгвөл шарлага үүсэхээс өмнө энэхүү хамгаалалт болон хариу арга хэмжээг авна. Цацрагийн аюулгүйн нормын 14 дүгээр зүйлийн хүснэгт 14.1-д заасан шарлагын тун үүссэн бол Ноцтой детерминистик нөлөөллөөс сэргийлэх хамгаалалтын болон бусад хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.
2. Хамгаалалтын арга хэмжээ болон бусад хариу арга хэмжээний үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, нөхцөл байдалд тохируулан өөрчилнө.
3. Арилаагүй буюу үлдсэн тунгийн хэмжээг тунгийн зөвлөх төвшинтэй харьцуулан үзэж, энэхүү тунгийн хэмжээ хэтэрсэн байвал тухайн бүлэг хүн амд хамгаалалтын арга хэмжээг хамгийн эхэнд авч хэрэгжүүлнэ.
4. Хэрэв шаардлагатай бол үүссэн нөхцөл байдал болон мэдээлэлд үндэслэн цаашдын хамгаалалтын стратеги, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4. Онцгой байдлын ажилтнуудын шарлага

4.4.1. Төрийн эрх бүхий байгууллага нь онцгой байдлын ажилтнуудын цацрагийн шарлагыг хянах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.4.2. Төрийн эрх бүхий байгууллага нь онцгой байдлын ажилтнуудын авсан цацрагийн тунг хянах, бүртгэх, зохион байгуулах хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлнэ.

4.4.3. Онцгой байдлын ажилтнуудын авсан цацрагийн тунг хянах, бүртгэх, зохион байгуулах хөтөлбөрийг онцгой байдлын болон цацрагийн хяналтын чиг үүрэг бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

4.4.4. Энэхүү хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ нь “Цөмийн болон цацрагийн ослын үеийн бэлэн байдлын менежментийн систем”-д тусгагдсан байна.

4.4.5. Ослын шарлагын нөхцөлд онцгой байдлын ажилтнуудад төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагууд мөн тавигдана. Гэвч цацрагийн тунгийн хэмжээ нь дараахаас бусад нөхцөлд 50мЗв-ээс хэтрэхгүй байна. Үүнд:

1. Хүний амь насыг аврах ажиллагаа;
2. Их хэмжээний гэмтлээс сэргийлэх ажиллагаа;
3. Детерминистик нөлөөллөөс сэргийлэх ажиллагаа;
4. Хүн ам, байгаль орчинд аюултай нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх ажиллагаа;
5. Их хэмжээний коллектив тун авахаас сэргийлэх ажиллагаа.

4.4.6. Энэ дүрмийн 4.4.5-д заасан тусгай нөхцөл байдлын үед онцгой байдлын ажилтнуудын авах тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжтой бүх арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд Цацрагийн аюулгүйн нормын 14 дүгээр зүйлд заасан Хүснэгт 14.2-т заасан зөвлөх төвшнөөс хэтрэхгүй байвал зохино. Тус үйл ажиллагааг гүйцэтгэхдээ онцгой байдлын ажилтнууд нь энэхүү хүснэгтэд заасан тунгийн утгаас хэтэрч байгаа эсэхийг хянуулах ба бусдад үзүүлэх ач тус нь өөрт учирч буй эрсдэлээс илүү гэж үзсэн тохиолдолд л гүйцэтгэнэ.

4.4.7. Онцгой байдлын болон цацрагийн хяналтын чиг үүргийн байгууллага нь 50мЗв-ээс их тун авч болзошгүй ажиллагааг сайн дураар гүйцэтгэх онцгой байдлын ажилтанд эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны боломжит арга хэрэгслийн талаар бүрэн мэдээллийг өгч, аврах ажиллагаанд оролцох бүлэгт нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, боломжит бүхий л сургалтад хамруулна.

4.4.8. Онцгой байдлын болон цацрагийн хяналтын чиг үүргийн байгууллага нь онцгой байдлын ажилтны ослын нөхцөлд авсан тунгийн хэмжээг үнэлж, бүртгэн баримтжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Аврах ажиллагаанд оролцсон мэргэжилтэн, аврагчдын тунгийн мэдээлэл болон эрүүл мэндийн эрсдэлийн мэдээллийг танилцуулж, эмчийн зөвлөгөөнд оруулан, мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулна.

4.4.9. Ослын шарлагын нөхцөлд тун авсан ажилтнууд нь цаашид мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад байхыг хориглохгүй. Гэхдээ 200мЗв-ээс их тун авсан ажилтныг эсвэл хүсэлт гаргасан ажилтныг мэргэжлийн эмчийн зөвлөгөөнд оруулж, мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулна.

4.5. Ослын шарлагын нөхцөлөөс үүсэж тогтсон шарлагын нөхцөлд шилжүүлэх

4.5.1. Төрийн эрх бүхий байгууллага нь ослын шарлагын нөхцөлөөс үүсэж тогтсон шарлагын нөхцөлд шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг бий болгосон байна.

4.5.2. Үүрэг хариуцлага бүхий байгууллагууд харилцан хамтран ажиллаж, бусад оролцогч талуудыг хамруулан ослын шарлагын нөхцөлөөс үүсэж тогтсон нөхцөлд шилжүүлэх шийдвэрийг гаргана.

4.5.3. Ослын дараа үйлдвэрийг засах, цацраг идэвхт хаягдлын байгууламж барих, ажиллуулах, ослын талбай болон орчин тойрны цацрагийн бохирдлыг арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд нөхөн сэргээх үйл ажиллагаа нь төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагын шаардлагуудыг хангаж ажиллана.

Тав. Үүсэж тогтсон шарлагын нөхцөлд
цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг
хангах шаардлагууд

5.1. Хамрах хүрээ

5.1.1. Дараах үйл ажиллагаанаас үлдсэн цацраг идэвхт материалаар бохирдсон талбайгаас авах шарлага хамаарна.

1. Өмнө нь цацрагийн хяналтад хамрагдаж байгаагүй үйл ажиллагаа;
2. Хяналтад байсан боловч энэхүү дүрмийн шаардлагыг хангаагүй аливаа үйл ажиллагаа;
3. Цөмийн болон цацрагийн ослын нөхцөлөөс үүсэж тогтсон нөхцөл байдалд шилжүүлсэн.

5.1.2. Дүрмийн 5.1.1-д заасан үйл ажиллагаанаас үлдсэн цацраг идэвхт материалын цацраг идэвхт цөмүүдийг агуулсан түүхий эд, бараа бүтээгдэхүүн, хоол, хүнс, тэжээл, ундны ус, барилгын материалаас авах шарлага

5.1.3. Байгалийн цацрагийн шарлага. Үүнд:

1. Төлөвлөгдсөн шарлагын нөхцөлд хамаарсан уран ба торийн гинжин задралын цөмүүдээс шарлага үүсгэх ажлын байрнаас бусад ажлын байр, мөн гэр орон болон хүмүүс байрлах өндөр үзүүлэлттэй (удаан хугацаагаар байнга байх) бусад барилгын ^{222}Rn ба түүний задралын бүтээгдэхүүн, ^{220}Rn ба түүний задралын бүтээгдэхүүнээс авах шарлага;
2. Байгалийн гаралтай цацраг идэвхт цөм агуулсан түүхий эд, бараа бүтээгдэхүүн, хоол, хүнс, тэжээл, ундны ус, барилгын материалаас авах шарлага;
3. Ураныг 1Бк/гр, Торийг 1Бк/гр, Калийг 10 Бк/гр-аас бага хэмжээгээр агуулсан бусад материалуудаас авч буй шарлага;
4. Сансрын хөлөг болон агаарын хөлгөөр нисэх үед авах шарлага.

5.2. Ерөнхий шаардлагууд

5.2.1. Төрийн эрх бүхий байгууллага нь үүсэж тогтсон шарлагын нөхцөлийг тогтоож, хүн амын болон мэргэжлийн шарлагыг үнэлэн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээг бий болгосон байна.

5.2.2. Төрийн эрх бүхий байгууллага нь үүсэж тогтсон шарлагын нөхцөлийг тогтоосон бол түүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах байгууллага болон тохирох зөвлөх төвшинг тогтоох зохион байгуулалтыг бий болгоно.

5.2.3. Үүсэж тогтсон шарлагын нөхцөлийн менежментийн цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах хяналтын тогтолцоог бий болгоно.

5.2.4. Хяналтын байгууллага эсвэл бусад зохицуулах байгууллагууд нь үүсэж тогтсон шарлагын нөхцөлд хамгаалалтын стратегийг бий болгож хэрэгжүүлнэ.

5.2.5. Хяналтын байгууллага эсвэл бусад зохицуулах байгууллагууд нь үүсэж тогтсон шарлагын нөхцөлийн хамгаалалтын стратегид дараах зүйлийг оруулна. Үүнд:

1. Боломжит нөхөн сэргээлтийн болон хамгаалалтын үйл ажиллагааг үнэлэн тогтоох зохион байгуулалт;
2. Төлөвлөсөн болон гүйцэтгэсэн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэн тогтоох зохион байгуулалт;
3. Цацрагийн шарлагад өртөж болзошгүй хүн бүрд эрүүл мэндэд учрах эрсдэлийн талаарх мэдээллийн ил тод байдал;
4. Цацрагийн шарлагад өртөж болзошгүй хүн бүрд шарлагын бууруулах, эрүүл мэндэд учрах эрсдэлийг бууруулах мэдээллийн ил тод байдал.

5.3. Хүн амын шарлага

5.3.1. Энэхүү дүрмийн 5.1.1-д заасан үйл ажиллагаанаас үүсэх шарлагаас хүн амыг хамгаалах, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад үндэслэлтэй байх, үр ашигтай байх, цацрагийн тунг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авах зарчмыг баримтална.

5.3.2. Хяналтын байгууллага болон холбогдох зохицуулагч байгууллагууд нь нөхөн сэргээх болон хамгаалалтын арга хэмжээг үндэслэлтэй байх, цацрагийн тунг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авах зарчмыг хангуулна. */Зохицуулагч байгууллагууд гэдэг нь Байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллагааг хангуулах, ослын үеийн бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээ авах, зохицуулах зэрэг үүрэг хариуцлага бүхий бусад байгууллагууд юм/*

5.3.3. Хяналтын байгууллага болон холбогдох зохицуулагч байгууллагууд нь тухайн нөхөн сэргээх болон хамгаалалтын арга хэмжээний ашиг тус нь тодорхойлсон цацрагийн эрсдэлтэй харьцуулахад илүү гэдгийг баталгаажуулна.

5.3.4. Хяналтын байгууллага болон холбогдох зохицуулагч байгууллагууд нь тухайн нөхөн сэргээх болон хамгаалалтын арга хэмжээ нь хэрэгжих боломжтой, үр ашигтай, цацрагийн тунг бууруулах боломжит арга хэмжээ гэдгийг баталгаажуулна.

5.3.5. Энэхүү нөхөн сэргээх болон хамгаалалтын арга хэмжээ нь шарлагад өртөж болзошгүй бүх хүнд чиглэсэн байх ба зөвлөх төвшнөөс их шарлагад өртөж болзошгүй буюу өртсөн хүмүүст хамгийн түрүүнд чиглэсэн байна.

5.3.6. Зөвлөх төвшнөөс хэтэрсэн шарлагаас сэргийлэх боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.3.7. Үүсэж тогтсон шарлагын нөхцөлд зөвлөх төвшин нь хүн амын эффектив тунгийн хувьд хэмжээ 1-20мЗв-ийн мужид байна.

5.3.8. Хяналтын байгууллага болон холбогдох зохицуулагч байгууллагууд нь зөвлөх түвшний хэмжээг давтамжтайгаар нягтлан үзэж, нөхцөл байдалд шаардлага хангасан гэдгийг баталгаажуулна.

Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээх

5.3.9. Төрийн эрх бүхий байгууллага нь цөмийн болон цацрагийн осол эсвэл өмнөх үйл ажиллагаанаас үлдсэн цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээх дараах зохион байгуулалтын арга хэмжээ авна. Үүнд:

1. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг судлан тогтоох, нөхөн сэргээх зардлыг холбогдох байгууллагын төсөвт суулгана.
2. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг судлан тогтоох, нөхөн сэргээх үйл ажиллагааг гүйцэтгэх, үр дүнг баталгаажуулах чиг үүргийг холбогдох байгууллагад олгоно.
3. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээхээс өмнө болон нөхөн сэргээлтийн явцад ашиглах, түүнд нэвтрэхийг хязгаарлах, шаардлагатай бол нөхөн сэргээсний дараа ч хязгаарлах зохицуулалтыг хангуулна.
4. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайн бохирдлын шинж чанар, хэмжээ зэрэг мэдээллүүд, нөхөн сэргээлтийн өмнөх, явцын, дараах шийдвэрүүд, нөхөн сэргээлтийн үр дүнгийн мэдээлэл, нөхөн сэргээлтийн дараах хяналт мониторингийн үр дүнгийн мэдээлэл зэргийг баримтжуулан хадгалах системийг бий болгох зохион байгуулалтыг хийнэ.

5.3.10. Төрийн эрх бүхий байгууллага нь цөмийн болон цацрагийн осол эсвэл өмнөх үйл ажиллагаанаас үлдсэн цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээх үйл ажиллагаанаас гарах хаягдлын менежментийн стратеги, төлөвлөлтболон, түүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зохион байгуулалтыг бий болгоно.

5.3.11. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг судлан тогтоох, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, нөхөн сэргээлтийн дүнг баталгаажуулах байгууллага нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө, цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээ зэргийг боловсруулан Хяналтын байгууллага эсвэл бусад холбогдох зохицуулах байгууллагад хянуулан батлуулахаар илгээнэ.
2. Нөхөн сэргээх төлөвлөгөөний эцсийн дүн нь цацрагийн эрсдэлийг эрчимтэй бууруулах ба хугацааны хувьд үр ашигтайгаар гүйцэтгэгдэж, тус талбайг ашиглалтад оруулах, хязгаарлалтгүйгээр нэвтэрдэг болоход чиглэгдэнэ.
3. Нөхөн сэргээх үйл ажиллагаанаас хүн амын авах нэмэлт тун нь үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх зарчмыг хангасан байх ба нөхөн сэргээх үйл ажиллагааны дараа хүн амын жилд авах тунг бууруулах үр ашигтай байна.
4. Нөхөн сэргээх үйл ажиллагаанд цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгахад дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

а) Хүн ам болон байгаль орчинд учирч буй цацрагийн болон цацрагийн бус сөрөг нөлөөлөл, нийгэм болон эдийн засгийн хүчин зүйлүүд;

б) Цацраг идэвхт хаягдлын менежмент ба тээвэрлэлтийн зардал, цацраг идэвхт хаягдлын менежментээс ажилтнуудын эрүүл мэндэд учрах эрсдэл, цацрагийн шарлага, хаягдлын булшлалтаас цаашид хүн амд учрах шарлага;

5. Хүн амыг мэдээллээр хангах ба сонирхогч талуудыг нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүнгийн баталгаажуулалт, нөхөн сэргээх үйл ажиллагааны дагалдах хяналт, мониторингийн үйл ажиллагаанд оролцуулна.
6. Хяналт мониторингийн хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлнэ.
7. Үүсэж тогтсон шарлагын нөхцөл болон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах үйл ажиллагааг баримтжуулан хадгална.
8. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хэвийн бус нөхцөл байдлын тухай болон бусад тайлан мэдээллээр Хяналтын байгууллага болон бусад холбогдох зохицуулагч байгууллагыг хангана.
9. Нөхөн сэргээх үйл ажиллагааны эцсийн тайланг Хяналтын байгууллага болон бусад холбогдох зохицуулагч байгууллагад гаргаж өгнө.

5.3.12. Хяналтын байгууллага эсвэл бусад холбогдох зохицуулагч байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө болон цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээг хянан үзэж баталгаажуулах ба нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөнд орсон аливаа өөрчлөлтийг хянаж баталгаажуулна.
2. Цацрагийн аюулгүй ажиллагааны үнэлгээний арга, шалгуур үзүүлэлтүүдийг бий болгосон байна.
3. Хяналт мониторингийн хөтөлбөр, ажлын журам, бүртгэл зэргийг хянан үзнэ.

4. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хүн ам болон ажилтнуудыг цацрагийн шарлагад өртүүлж болзошгүй эсвэл байгаль орчинд цацрагийн сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй багаж төхөөрөмж, үйл ажиллагаанд өөрчлөлт орвол тэдгээрийг хянан үзэж, баталгаажуулна.
5. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хууль, дүрэм, стандартын шаардлагыг хангуулна.

5.3.13. Хяналтын байгууллага эсвэл бусад холбогдох зохицуулагч байгууллага нь нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа дууссаны дараа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн дараах хяналт мониторингийн хөтөлбөр, түүний хугацаа, үлдэж буй цацрагийн эрсдэл зэргийг хянан үзэж, шаардлагатай бол нэмэлт оруулна.
2. Нөхөн сэргээлтийн дараах хяналт мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага болон этгээдийг тогтооно.
3. Хэрэв шаардлагатай бол дараах хязгаарлалтын арга хэмжээг авна. Үүнд:

а) Зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхийг хязгаарлах;

б) Талбайгаас цацраг идэвхт материалыг гаргах, ашиглах, түүний бүтээгдэхүүнийг ашиглахыг хязгаарлах;

в) Ирээдүйд талбайг ашиглах, талбайг хоол, хүнс, тэжээл, ус үйлдвэрлэх зориулалтаар ашиглахыг хязгаарлах;

5.3.14. Нөхөн сэргээлтийн дараах хяналт мониторингийг гүйцэтгэх байгууллага нь Хяналтын байгууллага эсвэл бусад холбогдох зохицуулагч байгууллагын заасан хугацааны туршид тус хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхөн сэргээлтийн үр дүн нь урт хугацаанд хадгалагдаж буйг баталгаажуулна.

5.3.15. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий тэдгээр талбайнуудыг Төрийн эрх бүхий байгууллага нь эдийн засаг нийгмийн үйл ажиллагаанд дахин ашиглах, оршин суухыг зөвшөөрсөн шийдвэр гаргасан бол Төрийн эрх бүхий байгууллага нь бусад сонирхогч талуудтай зөвшилцөн амьдрахад эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор шарлагын хяналтыг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд шаардлагатай зохион байгуулалтын дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Өдөр тутмын амьдралд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг ханган цацрагийн зөвлөх төвшинг тогтооно.
2. Тус талбайд өөрсдийгөө хамгаалах мэдээлэл, зөвлөгөө, мониторингийн арга хэмжээг хангах дэд бүтцийг бий болгосон байна.

5.3.16. Хэрэв хяналтын байгууллага нь нөхөн сэргээлтийн үйл ажиллаа бүрэн дууссаны дараа тус талбайд ямар нэгэн хязгаарлалт эсвэл хяналт тавиагүй бол тус талбайд

суурьших, шинээр байгууламж барих, үйл ажиллагаа явуулах үндсэн дэвсгэр төвшинд хүрсэнд тооцож болно.

Орон байрны радоноос хүн амын авах шарлага

5.3.17. Төрийн эрх бүхий байгууллага нь орон байрны радоны төвшин, эрүүл мэндэд учрах эрсдэлийн талаар мэдээллээр хүн амыг хангах, шаардлагатай бол орон байрны радоноос авах хүн амын шарлагын хяналт хийх төлөвлөгөөг бий болгож, хэрэгжүүлнэ.

5.3.18. Төрийн эрх бүхий байгууллага нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Хүмүүс байнга байх үзүүлэлт өндөр орон байрууд (цэцэрлэг, сургууль, эмнэлэг гэх мэт) болон хүн амын орон сууцанд радоны хэмжилт хийж, радоны идэвхийн агуулгын мэдээллийг бүрдүүлнэ.
2. Радон болон түүний эрүүл мэндэд учруулах эрсдэл, тамхины цацрагийн эрсдэлийн талаарх мэдээллээр хүн ам болон сонирхогч талуудыг хангана.

5.3.19. Хүн амын гэр орон болон хүн ам байнга байх үзүүлэлт өндөр орон байруудын радоны идэвхийн агуулгын мэдээллийг үндэслэн баригдсан орон байр болон шинээр баригдах орон байруудад радоны идэвхийн агуулгыг бууруулах төлөвлөгөө бий болгож хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

1. Гэр орон болон хүн ам байнга байх үзүүлэлт өндөр орон байруудад зөвлөх төвшинг тогтоосон байна.
2. Гэр орон болон хүн ам байнга байх үзүүлэлт өндөр орон байруудад радоны идэвхийн агуулга нь Цацрагийн аюулгүйн нормын 8 дугаар зүйлийн 8.2-т заасан хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.
3. Радоны идэвхийн агуулгыг бууруулах хамгаалалтын үйл ажиллагаа нь нийгэм эдийн засгийн хүчин зүйлийг харгалзсан боломжит арга хэмжээ байна.
4. Барилгын тухай хууль, дүрэм, журмуудад радоны идэвхийн агуулга ихсэхээс сэргийлэх арга хэмжээ, багасгах, залруулах арга хэмжээний заалтуудыг оруулна.

5.3.20. Төрийн эрх бүхий байгууллага нь хүн амын гэр орон болон хүн ам байнга байх үзүүлэлт өндөр орон байруудын радоны идэвхийн агуулгыг хянах дараах чиг үүргийг холбогдох байгууллагад олгоно. Үүнд:

1. Орон байрны радоныг хянах төлөвлөгөө бий болгох;
2. Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан хаана ямар хяналт, хамгаалалтын арга хэмжээ авах, ямар нь заавал гүйцэтгэх, ямар нь сайн дурын буюу хүсэлтээр хийгдэх зэрэг нөхцөлүүдийг тодорхойлох;
3. Орон байрны радоныг хянах төлөвлөгөө хэрэгжүүлэх;
4. Радоны идэвхийн агуулгыг бууруулах төлөвлөгөө бий болгож хэрэгжүүлэх.

Бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн цацраг идэвхт цөмөөс авах хүн амын шарлага

5.3.21. Хяналтын байгууллага болон бусад холбогдох зохицуулах байгууллага нь бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулгын зөвлөх төвшинг тогтооно.

5.3.22. Хяналтын байгууллага болон бусад холбогдох зохицуулах байгууллага нь барилгын материал, хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, ундны ус, нүүрс зэрэг бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн цацраг идэвхт цөмийн зөвлөх төвшинг хүн амын жилийн зөвшөөрөгдөх тун 1мЗв-ээс хэтрэхгүй байхаар тооцоолон тогтооно.

5.3.23. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга нь Цацрагийн аюулгүйн нормын 9 болон 15 дугаар зүйлд заасан хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

5.3.24. Барилгын материал, түүний түүхий эдэд агуулагдах цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга нь Цацрагийн аюулгүйн нормын 12 дугаар зүйлийн 12.1-д заасан хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

5.3.25. Нүүрсэнд агуулагдах цацраг идэвхт цөмийн идэвхийн агуулга нь Цацрагийн аюулгүйн нормын 12 дугаар зүйлийн 12.2-д заасан хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

5.3.26. Хяналтын байгууллага болон бусад холбогдох зохицуулах байгууллага нь цөмийн болон цацрагийн ослын үед Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Хүнсний олон улсын байгууллагаас тогтоосон ундны ус болон хоол, хүнсний зөвлөх төвшинг баримтална.

5.4. Мэргэжлийн шарлага

5.4.1. Энэхүү дүрмийн 5.1.1-д заасан үйл ажиллагаанаас үүсэх шарлагаас ажилтнуудыг хамгаалах, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангахад үндэслэлтэй байх, үр ашигтай байх, цацрагийн тун аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авах зарчмыг баримтална.

5.4.2. Хяналтын байгууллага болон холбогдох зохицуулагч байгууллагууд нь нөхөн сэргээх болон хамгаалалтын арга хэмжээг үндэслэлтэй байх, цацрагийн тунг аль болох бага байлгах боломжтой арга хэмжээг авах зарчмыг хангуулна.

5.4.3. Энэхүү дүрмийн 5.3.3-аас 5.3.8-д заасан заалтууд энэхүү бүлэгт мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээхэд ажилтнуудыг хамгаалах

5.4.4. Цацраг идэвхт материалын үлдэгдэл бүхий талбайг нөхөн сэргээхэд ажилтнуудын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагааг энэхүү

дүрмийн 3 дугаар зүйлд заасан төлөвлөгдсөн шарлагын нөхцөлийн мэргэжлийн шарлагын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагуудын дагуу гүйцэтгэнэ.

Ажлын байранд радоноос авах шарлага

5.4.5. Хяналтын байгууллага болон холбогдох бусад зохицуулах байгууллага нь ажлын байранд радоны шарлагаас хамгаалах стратеги, зөвлөх төвшинг тогтооно.

5.4.6. Ажлын байранд радоны идэвхийн агуулга нь Цацрагийн аюулгүйн нормын 8 дугаар зүйлийн 8.1-т заасан хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

5.4.7. Ажил олгогч нь ажлын байранд радоны идэвхийн агуулгын хэмжээг аль болох бага байлгах боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Агаарын хөлөг болон сансрын хөлгөөр нисэхэд сансрын цацрагаас авах шарлага

5.4.8. Хяналтын байгууллага болон холбогдох бусад зохицуулах байгууллага нь агаарын хөлөг болон сансрын хөлгөөр нисэхэд сансрын цацрагаас авах шарлагыг үнэлэх шаардлагатай эсэхийг тогтооно.

5.4.9. Хяналтын байгууллага болон холбогдох бусад зохицуулах байгууллага нь агаарын хөлөг болон сансрын хөлгөөр нисэхэд сансрын цацрагаас авах шарлагыг үнэлэх шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд тунгийн зөвлөх төвшин, үнэлгээний арга, сансрын цацрагаас авсан мэргэжлийн шарлагын тунгийн дүнгийн бүртгэлийг хийх зохион байгуулалтыг бий болгоно.

5.4.10. Сансрын цацрагаас авах мэргэжлийн шарлагын тун нь зөвлөх төвшнөөс хэтэрсэн тохиолдолд ажил олгогч нь дараах арга хэмжээ авна. Үүнд:

1. Тунгийн үнэлгээг хийж, баримтжуулна.
2. Тунгийн үнэлгээний дүнг нисэх хөлөгт байрлуулна.
3. Эмэгтэй ажилтнуудад жирэмсэн бол эрт мэдээлэх хэрэгтэй гэдгийг мэдэгдэж, түүний ураг болон үр хөврөлд учирч болзошгүй эрсдэлийн талаар мэдээлэл өгнө.
4. Жирэмсэн гэдгээ мэдэгдсэн нь түүнийг ажлаас гаргах шалтгаан болох ёсгүй бөгөөд ажил олгогч буюу цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, этгээд нь түүнийг хэвийн ажлын нөхцөлтэй ажлын байранд шилжүүлэн ажиллуулна. Өөрөөр хэлбэл мэргэжлийн шарлагын нөхцөлийг өөрчилж, хүн амын гишүүнийг хамгаалахтай адил төвшинд хамгаалалт болон аюулгүй ажиллагааны арга хэмжээ авна.

5.4.11. Хяналтын байгууллага болон холбогдох бусад зохицуулах байгууллага нь сансарт үйл ажиллагаа явуулах хүний цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг тухайн сансрын үйл ажиллагаанд тохируулан хангах зохион байгуулалтын бий болгоно. Сансарт ажиллах хүнд цацрагийн тунгийн зөвшөөрөгдөх хязгаар тавигдахгүй боловч цацрагийн тунгийн хэмжээг аль болох бага байлгах боломжит арга хэмжээг тухайн сансрын үйл ажиллагаанд тохируулан авна.

xxxXXxxx